



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



*Empowered lives.
Resilient nations.*

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
УЯЛДАА ХОЛБООНД ҮНЭЛГЭЭ
ХИЙХ, БОДЛОГЫН ХҮРЭХ ТҮВШИНГ
ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙ
(Тайлан II)**

Улаанбаатар хот
2018 он



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



Empowered lives.
Resilient nations.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН УЯЛДАА ХОЛБООНД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, БОДЛОГЫН ХҮРЭХ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙ

(Тайлан II)

Улаанбаатар хот
2018 он

АЖЛЫН БАГ

Судалгааг удирдан зохион байгуулагчид

Б.Баярсайхан, Үндэсний хөгжлийн газрын дарга, Докторант
Ж.Должинсүрэн, Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Докторант
С.Сюзанна, Х.Онон, Э.Тодмэргэн, Л.Амарбаясгалан, Д.Эрхэмбаяр, Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүд

Судлаачид

ШУ-ны доктор А.Даваасүрэн (Багийн ахлагч)
Доктор Б.Батмөнх
Доктор О.Бат-Эрдэнэ
Магистр Д.Лхагвадорж

Хянан тохиолдуулагч Доктор Б.Батхишиг

Энэхүү судалгааны ажлыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн техникийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэв.

Үндэсний хөгжлийн газрын судалгааны ажлууд нь хөгжлийн бодлогын чиглэлээр тулгамдаж буй чухал асуудлуудыг хөндлөнгийн судалгаан дээр тулгуурлан хөнддөг тул судалгааны санал, дүгнэлт нь тус газрын албан ёсны байр суурийг зайлшгүй илэрхийлэх албагүй болно.

Илтгэлийг ашгийн бус зорилгоор хуулбарлах, олшруулж тараахыг зөвшөөрнө.

ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо, түүний өнөөгийн байдал болон алдаа дутагдал, цаашдын сургамжийн талаар, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдааг үнэлэх, бодлогын тэргүүлэх чиглэл, үзүүлэлтийн хүрэх түвшинг тодорхойлох, төлөвлөлтийн арга зүй, түүнчлэн 2020-2025 оны дунд хугацааны хөгжлийн хүрээ зэргийг тодорхойлсон таван боть тайланг та бүхэнд толилуулж байгаадаа таатай байна.

Өнгөрсөн хугацаанд, Монгол Улс зах зээлийн шилжилтийг туулж, ардчилсан тогтолцоог нутагшуулсан 28 жилийн хугацаанд эдийн засаг өсч, хөгжлийн тодорхой хэд хэдэн үзүүлэлтүүдээрээ дэлхийн дундаж

түвшний хөгжилтэй орнуудын тоонд багтаж, уул уурхай, газар тариалан, барилга, худалдаа үйлчилгээний салбарт тодорхой ахиц дэвшилд хүрсэн боловч эдийн засгийн төрөлжилт, үйлдвэржилт, засаглал, дэд бүтэц, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон салбарын хөгжилд бэрхшээлүүд тулгарсан хэвээр байгаа билээ.

1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халснаас хойш хөгжлийн урт хугацааны хөгжлийн хэд хэдэн стратегийг боловсруулж байсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх бодлого хөтөлбөрүүд нь бодит байдалтай нийцгүй, залгамж чанаргүй, төсөвтэй уялдаагүй байсаар иржээ. Үүний зэрэгцээ дөрвөн жил тутам зохион байгуулагддаг сонгуулийн циклийг даган Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, чиглэл ойр ойрхон өөрчлөгддөг, мөн бодлогын баримт бичгүүд хэт олширсон тэдгээрийн хоорондын уялдаа хангагддаггүй зэргээс үүдэн хөгжлийн бодлогын баримт бичгүүд үр дүнтэй хэрэгжээгүй байна.

Үүний улмаас, Монгол Улсын хөгжил тогтворгүй, эмзэг, баялгийн тэгш бус хуваарилалт нэмэгдсэн, иргэдийн төрд итгэх итгэл суларсан, нийтээрээ хөгжлийн талаарх нэгдсэн ойлголтгүй болсон гэх мэт олон сөрөг үр дагаврууд бий болжээ. Энэ бүх хугацаанд хөгжлийн талаарх олон баримт бичиг, бодлогууд боловсруулж батлуулсан боловч нийгэмд нийтээрээ хүлээн зөвшөөрөгдөхүйц бодит өөрчлөлт, үр дүнд хүрэхгүй байгаа нь улсын тогтвортой хөгжлийн нэгдсэн ойлголт, бодлого, зохицуулалт, түүнийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм, хууль эрх зүйн орчин дутагдалтай байсны илрэл юм.

Үүний мөрөөр, Үндэсний хөгжлийн газар (ҮХГ)-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын өнөөгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог шинэчлэх, шинжлэх ухаан, тооцоо судалгаанд үндэслэн харилцан уялдаа бүхий бодлого, стратеги боловсруулдаг байх, түүнд чиглэсэн чадавхыг сайжруулах зорилгоор энэхүү таван боть тайланг боловсрууллаа. Энэхүү тайланд судалсан арга

зүйг Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго (ДТХЗ)-уудыг хэрэгжүүлэхэд хэрэглэж буй олон улсын сайн туршлагад үндэслэн манай орны салбар бүрийн төрийн болон төрийн бус байгууллагын, мэргэжлийн судлаачдын олон талын төлөөллийн үнэтэй санал, зөвлөмжийг тусган боловсруулсан. Энэхүү тайланд тусгагдсан арга зүй, санал зөвлөмжүүдийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх ажлууд үргэлжлэн хийгдэх бөгөөд цаашид Монгол Улсад цэгцтэй, уялдаатай, залгамж чанар бүхий бодлого, хөтөлбөр, механизмуудтай, харилцан уялдаа бүхий зохицуулалттай төрийн институцтэй, зах зээлийн эдийн засагт нийцсэн төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх бидний хүчин чармайлт биелэлээ олно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү таван боть тайланг боловсруулах ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн удирдлагаар ханган бүх талаар дэмжин ажилласан ҮХГ-ын дарга Б. Баярсайхан танд гүн талархлаа илэрхийлье. Мөн түүнчлэн, тайланг боловсруулахад нөр их хөдөлмөр, хичээл зүтгэл гаргаж ажилласан судлаачдын баг болон тайланг боловсруулахад бүхий л талаар оролцон хөдөлмөр зүтгэлээ гаргасан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүд болох С.Сюзанна, Х.Онон, Э.Тодмэргэн, Л.Амарбаясгалан, Д.Эрхэмбаяр, Р.Сийлэн нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Түүнчлэн, манай улсын хөгжлийн төлөвлөлтийг сайжруулахад үнэ цэнэтэй дэмжлэг туслалцаа өгч, хамтран ажилласан Нэгдсэн Үндэстний Байгуулга (НҮБ)-ын Монгол дахь суурин зохицуулагч, НҮБХХ-ийн суурин төлөөлөгч хадагтай Беате Транкманн, НҮБХХ-ийн орлогч суурин төлөөлөгч хадагтай Даниела Гаспарикова болон НҮБХХ-ийн хамт олонд гүн талархалаа илэрхийлье.

**Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Жамбалын Должинсүрэн**

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗАГВАР МАТРИЦ

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

**БҮЛЭГ 1. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН НИЙТЛЭГ
АРГА ЗҮЙ, ЗАРЧИМ**

1

**БҮЛЭГ 2. УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ
БИЧГҮҮДИЙН УЯЛДААГ ШАЛГАХ, НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙ**

2.1. Хөгжлийн бодлогын уялдааг шалгах, нөлөөллийг
үнэлэх ерөнхий арга зүй

7

2.2. Чиглэл тус бүрээр бодлогын уялдааг шалгах, үнэлэх арга зүй

10

**БҮЛЭГ 3. ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ДАРААЛАЛ, ХҮРЭХ ТҮВШИНГ
ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙ**

3.1. Хөгжлийн тэргүүлэх чиглэл, дарааллыг тодорхойлох арга зүй

31

3.2. Үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг тодорхойлох арга зүй

37

3.2.1. МУТХҮБ-2030-ын үндсэн үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг
тооцох арга зүй

37

3.2.2. ДТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтүүдийн хүрэх
түвшинг тооцох арга зүй

47

НОМ ЗҮЙ

51

ХАВСРАЛТ

52

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бодлогын зорилтуудын хоорондын уялдаа, нөлөөг тодорхойлох оноо	8
Хүснэгт 2. ДТХЗ-д тодорхойлсон бодлогын бүх зорилтууд, МУТХҮБ-2030-д тусгагдсан байдал	12
Хүснэгт 3. МУТХҮБ-2030-ын сонгосон зорилтууд	14
Хүснэгт 4. Нөлөөллийг үнэлэх матрицын ерөнхий загвар	15
Хүснэгт 5. "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан зарим сонгосон үйл ажиллагаанууд	27
Хүснэгт 6. Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын 2030 он хүртэлх өсөлтийн тооцоо	38
Хүснэгт 7. Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО	39
Хүснэгт 8. Хүн амын тоо дундаж хувилбараар	41
Хүснэгт 9. ДНБ-ий 2014-2030 оны хүрэх түвшний төсөөлөл	41
Хүснэгт 10. ДНБ-ий хэмжээ болон өсөлт	42
Хүснэгт 11. ДНБ-ий өсөлт	42
Хүснэгт 12. Эрчим хүчний суурилагдсан хүчин чадал	45
Хүснэгт 13. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн 2030 он хүртэлх жил бүрийн хүрэх түвшний төсөөлөл	46
Хүснэгт 14. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл	46
Хүснэгт 15. Ажил эрхэлж буй нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, өсөлт	48
Хүснэгт 16. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн хэтийн тооцоо, 3 хувилбараар	49

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Харилцан уялдаатай, дээрээс доош задарсан бүтэцтэй зорилго, зорилтуудаа тодорхойлох дараалал	2
Зураг 2. ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын сонгосон зорилтууд хоорондоо уялдсан байдал	17
Зураг 3. Дээрээс доош төлөвлөх төсөөлөл	32
Зураг 4. Хөгжлийн бодлогын зорилго, зорилтуудын эрэмбэ	33
Зураг 5. Салбарын хөгжлийн бодлогын зорилго, зорилтууд	33
Зураг 6. Асуудлын мод	35
Зураг 7. ДНБ-ий жил бүрийн бодит өсөлт, бууралт	43
Зураг 8. ДНБ-ий өсөлт	44
Зураг 9. Нялхсын эндэгдлийн түвшин	47
Зураг 10. Хөдөлмөрийн бүтээмж	50

ЗАГВАР МАТРИЦ

Загвар матриц 1. ДТХЗ-д тодорхойлсон бодлогын зорилтууд МУТХҮБ-2030-д хэрхэн тусгагдсаныг хянах матриц	10
Загвар матриц 2. ДТХЗ-д тодорхойлсон бодлогын сонгосон зорилтууд МУТХҮБ-2030-д хэрхэн тусгагдсан байдлын үнэлгээ	11
Загвар матриц 3. МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилт ДТХЗ-ын Зорилго 1-д үзүүлэх нөлөөг оноогоор үнэлэх жишээ	15
Загвар матриц 4. МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд салбарын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогод тусгагдсан байдал	18
Загвар матриц 5. ДТХЗ, МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд ТЭХТББ-д тусгагдсан байдал	18
Загвар матриц 6. МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилт ТЭХТББ-д хэрхэн нөлөөлөх байдлын үнэлгээ	21
Загвар матриц 7. ТЭХТББ МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилтод хэрхэн нөлөөлөх байдлын үнэлгээ	21
Загвар матриц 8. ХАА-н салбарын хөгжлийн бодлогын, баримт бичгүүдийн уялдаа	23
Загвар матриц 9. ТХХААТББ-ын "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ	25
Загвар матриц 10. МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан байдал	26
Загвар матриц 11. ТЭХТББ-д тодорхойлсон зорилго, зорилтууд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан байдал	26
Загвар матриц 12. "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн ТЭХТББ-ын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөлөл	27
Загвар матриц 13. ТЭХТББ-ын "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөөлөл	28
Загвар матриц 14. Ач холбогдлоор нь дараалал тодорхойлох заавар	35
Загвар матриц 15. Хэрэгжилтийн дараалал тодорхойлох заавар	35
Загвар матриц 16. Газар тариалангийн тулгамдсан асуудлуудын харилцан нөлөөлөл, уялдаа	36

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Сайн бодлого, төлөвлөлтийн 10 шалгуур ба шаардлага	52
Хавсралт 2. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан байдал	54

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУТХҮБ-2030 - Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

ДТХЗ - Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго

НҮБ - Нэгдсэн Үндэстний Байгууллага

НҮБХХ - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

ОУВС - Олон Улсын Валютын сан

ДХБ - Дэлхийн худалдааны байгууллага

УИХ - Улсын Их Хурал

МАХН - Монгол Ардын Хувьсгалт нам

ҮХГ - Үндэсний хөгжлийн газар

ҮСХ - Үндэсний статистикийн хороо

МУИС - Монгол Улсын Их Сургууль

ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн

ОХУ - Оросын Холбооны Улс

БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс

АНУ - Америкийн Нэгдсэн Улс

ҮНО - Үндэсний нийт орлого

МАА - Мал аж ахуй

ХАА - Хөдөө аж ахуй

ТХХААтББ - Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого

ТЭХтББ - Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого

ТЭЗҮ - Техник эдийн засгийн үндэслэл

ДЦС - Дулааны цахилгаан станц

БҮЛЭГ 1. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН НИЙТЛЭГ АРГА ЗҮЙ, ЗАРЧИМ

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн олон улсын жишиг арга зүй, зарчим нь манай оронд боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ хийх, уялдаа холбоог нь шалгахад баримтлах арга зүйн гол чиглэл болж чадах тул энд зориуд авч үзлээ.

Хөгжингүй орнууд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр 1980-аад оны дундаас шинэ үзэл баримтлал, хандлагын асуудлыг хөндөж эхэлсэн. Энд “Multidisciplinary Approach” буюу шинжлэх ухааны олон салбарт суурилсан аргыг хэрэглэхийг чухалчилдаг болсон. Энэ нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны талаар иж бүрэн шинжилгээ судалгаа хийж, түүн дээр үндэслэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хийх арга юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хийхэд өмнөхөөсөө шинэ арга хандлага хэрэглэх болсон. Үүнд:

Нэн тэргүүнд “Participatory Approach” буюу төрөл бүрийн салбарын төлөөллийн оролцоотой хөгжлийг төлөвлөх аргыг нэн чухалчилдаг болсон. Энэ нь хөгжлийн бодлого, төлөвлөлтөд олон талын төлөөллийг өргөн оролцуулах арга юм. Уг арга нь олон талын төлөөллийг зөвхөн төлөвлөлтийн шатанд төдийгүй, бас төлөвлөгөөг хэрэгжүүлэх буюу гүйцэтгэлийн шатанд хамтран оролцуулахыг шаарддаг.

Мөн “Science Based Approach” буюу шинжлэх ухаанд суурилсан арга нь бодлого, төлөвлөлтийг эдийн засаг, нийгэм, байгаль орчны талаарх судалгаа шинжилгээнд үндэслэн хийх арга юм.

Түүнчлэн “People Centred Approach” буюу хүний хөгжил, сайн сайхан байдлыг хөгжлийн төвд тавьсан бодлого, төлөвлөлтийн арга хандлага нь эдийн засгийг өсгөх аливаа нэг арга зам байгаль орчинд халтай, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бол түүнээс татгалзах зарчмыг илэрхийлнэ.

Олон улсын нийтлэг сайн туршлагаас үзэхэд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт нь үр дүнд суурилсан байх гол шалгуурыг хангахад чиглэгддэг. Үр дүнд чиглэсэн бодлого, төлөвлөлт нь хяналт-шинжилгээ, үнэлгээтэй нягт уялдсан байх шаардлагатай. Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт нь алсын хараа, эрхэм зорилго, зорилго, зорилтуудыг юуны түрүүнд харилцан уялдаа холбоотой, оновчтой тодорхойлсон байхаас эхэлдэг.

Алсын хараа, эрхэм зорилго, зорилго, зорилтуудаа тодорхойлохын өмнө нөхцөл байдлын шинжилгээ хийж, өмнөх түүх, өнөөгийн байдал, ойрын болон алс ирээдүйн хөгжил, өөрчлөлтийн хэгийн төлөв, хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлдог. Энэ шатанд SWOT шинжилгээг хийнэ. Энд хөгжлийн талаарх онол, бусад улсын практик туршлага, ололт амжилт, алдаа оноог судалж, харгалзан үзнэ.

Зураг 1. Харилцан уялдаатай, дээрээсээ доошоо задарсан бүтэцтэй зорилго, зорилтуудаа тодорхойлох дараалал



НҮБ-аас 2000 онд баталсан Мянганы хөгжлийн зорилгууд болон 2015 онд баталсан ДТХЗ-ууд болох урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд энэхүү зарчмаар алсын хараа, эрхэм зорилго, зорилго, зорилтуудыг хэрхэн тодорхойлсныг харж болно.

Алсын хараа бол бүтээж бий болгох ирээдүйн төсөөлөл юм. Энэ нь хийсвэр ойлголт, итгэл үнэмшил биш, харин бодитой хэрэгжиж болохуйц төсөөлөл бөгөөд урт, дунд хугацааг хамарсан байж болно. Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт нэн тэргүүнд үндэсний түвшинд болон салбар, яам, аймгийнхаа алсын харааг өргөнөөр хэлэлцэж, оновчтой тодорхойлохоос эхэлдэг.

Эрхэм зорилго нь алсын харааг хэрэгжүүлэхэд үндэсний хэмжээнд болон тухайн салбар, орон нутгийн хувьд үндсэн чиг зорилго юу вэ? Түүнийг яаж төсөөлж харж байна? Юунд хүрэхийг хүсч байна? гэдгийг товчоор тайлбарлан тунхагласан урт хугацааны эрмэлзлийн илэрхийлэл юм.

Зорилго нь эрхэм зорилгод хүрэхэд тус дөхөм болох ирээдүйн томъёолол юм. Зорилгын томъёолол зөв, оновчтой эсэхийг тогтоох шалгуурууд байдаг. Зорилго нь англи хэл дээр SMART буюу ухаалаг шийдэл гэсэн үгний товчилсон шалгуурыг хангасан байна. Үүнд:

- S - Specific (зорилго тодорхой байх)
- M - Measurable (хэмжиж болохуйц)
- A - Achievable (зорилгодоо хүрч болохуйц байх)
- R - Realist (бодитой байх)
- T - Time (цаг хугацаатай байх)

Эх сурвалж: *An Introduction to the Policy Process: Theories, Concepts, and Model of Public Policy Making/ Third Edition, Thomas A. Birkland.*

Зорилтууд нь хүрэхээр зорьсон ирээдүйн зорилгын талаар илүү нарийвчлал бүхий тодорхой шинжүүдийн томъёолол, хэмжигдэхүйц алхмууд юм. Зорилго олон зорилтууд (Targets) болгон задлан тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлдэг. Зорилтууд нь хугацааны хувьд тодорхой, зөрчилгүй байх ёстой. Бодлогын баримт бичиг дэх өөр хоорондоо логик уялдаатай зорилтууд нь зорилгоо ханган биелүүлэхэд чиглэсэн байх шаардлагатай. Зорилго, зорилтуудаа тодорхойлохын өмнө доорх дүн шинжилгээнүүдийг заавал хийнэ.

Бодлого боловсруулах үе шатуудад хийх шаардлагатай дүн шинжилгээнүүд:

1. Нөхцөл байдлын дүн шинжилгээ
2. Оролцогч талуудын дүн шинжилгээ
3. Асуудлын дүн шинжилгээ (асуудлын мод аргачлалаар)
4. Зорилгуудын дүн шинжилгээ
5. Хувилбаруудын дүн шинжилгээ

Нөхцөл байдлын шинжилгээг хийж, өмнөх түүх, өнөөгийн байдал, ойрын болон алсын ирээдүйн хөгжил, өөрчлөлтийн хэтийн төлөв, хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлсон байна.

SWOT шинжилгээ нь дараах үндсэн 4 хэсгээс бүрдэнэ.

- Strength - Давуу тал
- Weakness - Сул тал
- Opportunities - Боломжууд
- Threats - Аюул занал

Шинжилгээний гол зорилго нь ирээдүйд сул талаа яаж давуу тал болгох, давуу талаа хэрхэн хадгалах, өөр шинэ давуу тал бий болгох, бодитой оршин буй аюул занал, эрсдэлийг хэрхэн даван туулах, байгаа боломжуудаа хэрхэн ашиглахыг төлөвлөж, алсын хараа, эрхэм зорилго, зорилго, бүх зорилтуудаа тодорхойлоход оршино.

Дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг талуудын оролцоотой боловсруулна. Олон улсын жишгээр бол ямар нэг тодорхой асуудлаар бодлого боловсруулахад зөвхөн зорилт дэвшүүлээд орхидоггүй, уг зорилтдоо ямар арга замаар хүрэх хувилбаруудыг боловсруулж, ямар тодорхой арга хэмжээ авах, ямар ажлуудыг хийж гүйцэтгэх тухай оролцогч талуудыг хамруулан сайтар хэлэлцэж, төлөвлөдөг байна. Аливаа бодлогын баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн, чадварлаг боловсон хүчний оролцоо нэн чухал юм. Бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан албан хаагчид нь хөгжлийн бодлого, төлөвлөлт болон хууль, эрх зүйн орчны талаар өндөр мэдлэг, туршлагатай байхын зэрэгцээ бодлого боловсруулах явцад үндсэн 6 асуудлыг заавал авч үзэх шаардлагатай. Үүнд:

1. Улс орны хууль, эрх зүйд нийцсэн байх;
2. Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах;
3. Байгалийн баялгийн хомсдлыг бууруулах;
4. Жендэрийн тэгш байдлыг хангах;
5. Орлогыг шударга хуваарилах, ядуурлыг бууруулах;
6. Бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг сайн хийх гол шалгууруудыг Хавсралт 1-д харуулав.

Төгсгөлд нь аливаа бодлогыг боловсруулахад ашигласан арга зүйн хувьд үнэлнэ. Тухайн бодлого нь тавьсан зорилгодоо ямар арга замаар хүрэх, хэрхэн яаж хэрэгжүүлэхийг заасан үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, ямар үр дүнд хүрэхийг хэмжих шалгуур үзүүлэлт, түвшинг цаг хугацааны ялгаатай тодорхойлсон, мөн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тооцсон байх шаардлагатай байдаг. Эдгээр иж бүрэн тооцоог хийж байж, бодлого боловсруулсан үндсэн шаардлага хангагдсан гэж үздэг.

Макро болон салбарын хөгжлийн бодлогуудын хувьд хөгжлийн зорилтоос эхлээд алсын хараа хүртэл доороос дээш харилцан нягт холбоотой, логик уялдаатай эсэхийг шалгаж, үнэлгээ хийнэ.

Энэ үе шатны гол зорилго бол зорилтууд нь зорилгынхоо хүрээнд оновчтой тодорхойлогдсон эсэх, зорилго нь зорилтуудаа нэгтгэсэн оновчтой байж чадаж байгаа эсэхийг үнэлэхэд чиглэгдэнэ. Манай орны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд зорилго, зорилтуудыг ялгаж, ангилаагүй тохиолдол цөөнгүй бий бөгөөд энэ нь олон улсын нийтлэг зарчмыг баримтлаагүйтэй холбоотой. Зорилгууд нь дотроо зорилтууд болж оновчтой задарсан эсэхийг ийнхүү үнэлэхээс гадна, тухайн салбарын алсын харааг дунд шатанд болон урт хугацаанд дэвшүүлсэн зорилгууд хэр хангаж чадах, тэдгээрийг бүрэн хэрэгжүүлсэн тохиолдолд алсын хараандаа хэр дөхөж ойртохыг тодорхой хэмжих үзүүлэлттэй бол боломжийн хэмжээгээр үнэлнэ. Хөгжлийн бодлогын баримт бичигт эрхэм зорилгыг тодорхойлсон бол эрхэм зорилго, алсын хараа, зорилгуудын уялдаанд үнэлгээ өгнө.

Шигтгээ 1: Малайз Улсын туршлагаас

1970 оноос 1991 он хүртэл Малайз улс хөгжлийн бүхий л үйл ажиллагаандаа “тэгш боломж олгосон өсөлт” уриаг баримталж иржээ. 20 жилийн турш энэхүү бодлого нь хоёр зорилгыг агуулж байсан: ядуурлыг арилгах болон эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд арьс өнгө, яс үндэстний ялгаварлалгүй байх. 1991 онд боловсруулсан 2020 он хүртэлх алсын хараа нь “Ёс суртахууны үнэт зүйлсээ дэмжсэн итгэл төгс Малайз”-ыг бий болгоход чиглэсэн байна. Улс орны “хөгжлийн үр шимийг бүх нийтээр ижил тэгш хүртэх боломж бий болгох, тогтвортой хөгжих, хэн нэгнийг орхигдуулахгүй, хүртээмжтэй байх” гэсэн уриаг баримталжээ. Үүний үр дүнд нэн ядуурлыг арилгаж, ядуурлыг 0,6 хувь хүртэл бууруулж чадсан. Мөн орлогын тэгш бус байдал огцом багасч, Жини коэффициент 2002 онд 0,46 байсан бол 2014 онд 0,4 болсон байна. Сүүлийн 15 жил Малайзын эдийн засаг тууштай өсч, ард иргэдийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг мэдэгдэхүйц өөд татсан. Жишээлбэл, 2013 онд 2005 оны түвшинтэй харьцуулахад дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д ногдох хүлэмжийн хийн ялгарлын эрчим 33 хувиар буурчээ. 2010 онд өрхийн дахин хэрэглээний түвшин 5 хувь байсан бол 2015 онд 15 хувь болсон. 2013 онд түлш хэрэглээний Евро 4 стандарттай болжээ. Сэргээгдэх эрчим хүчний хуулийг 2011 оноос хэрэгжүүлж, сэргээгдэх эрчим хүчийг буцаан нийлүүлэх тарифын механизм бий болгов. Үерээс хамгаалах 194 төсөл хэрэгжүүлснээр нэг сая хүн үерийн эрсдэлээс хамгаалагджээ.

Үерийн аюултай 34 газрыг тодорхойлж, зураглал боловсруулсан бөгөөд 2010 онд ойн бүрхүүл 56,4 хувь байсан бол 2014 онд 61 хувь болж нэмэгдсэн. Ойн нэгдсэн төв сангийн хүрээнд 23260 га талбай бүхий ойг байнгын хамгаалалттай ойн нөөцөд авсан зэрэг олон сайн жишээнүүд байна.

2016-2020 дунд хугацааны төлөвлөгөөний тулгуур стратегийн зорилт: Тогтвортой, бэрхшээлийг даван туулах чадвартай улс орон байхын төлөө ногоон өсөлтийг дэмжих.

Энэ зорилтын хүрээнд байгалийн нөөцийн үр ашигтай хэрэглээ, цэвэр бүтээгдэхүүнийг чухалчилсан байна. Уламжлалт эдийн засгийн өртөг зардал ихтэй загвараас татгалзаж, үйл ажиллагааныхаа эхнээс тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан ногоон өсөлтийг эргэж буцалтгүй тууштай хэрэгжүүлэхээр болсон байна. 20-30 жилийн урт хугацааны алсын хараатай Малайз Улс сүүлийн 30 гаруй жил 5, 10 жилийн дунд хугацааны төлөвлөгөө байнга хийж иржээ. Үндэсний хэмжээнд хүрсэн байх ёстой гол үр дүнг хэрэгжүүлэх гол механизм нь байгууллага хоорондын хамтын ажиллагаа бөгөөд гол үр дүн тус бүрээр хэрэгжилтийг тэргүүлэн хариуцах нэг сайд томилогддог. Сайд нар сар бүр Ерөнхий сайдад хэрэгжилтийн явцаа тайлагнадаг. Энэ нь амжилтанд хүргэсэн бас нэг хүчин зүйл юм. 2010 онд Үндэсний нийт орлого (ҮНО)¹-ыг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг эдийн засгийн гол чиглэлүүдийг тодорхойлохын тулд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон зөвлөлдөх уулзалтаар хэлэлцэж, тэдгээрийг сонгосон байна. Төлөөлөгчид хоёр сарын турш санал бодлоо уралдуулан ажилласан байна. Нийт 425 төлөөлөгч, үүний дотор 211 компанийг урьж бодитойгоор оролцуулжээ.

Дүгнэлт: Эдийн засгийг тогтвортой, тууштай хөгжүүлэхэд хүчирхэг төлөвшсөн хувийн хэвшил зайлшгүй шаардлагатай ч Малайз Улс зах зээлийн жам ёсны хүчинд бүхнийг найдаж орхиогүй, харин хөгжлийг төлөвлөгөөтэй хийх идэвхтэй арга барилыг баримталж ирсэн байна. Учир нь ядуурлыг арилгах, орлогыг тэгш, шударга хуваарилах зэрэг асуудлыг зах зээлийн зарчим хэзээ ч шийдэхгүй гэдгийг мэдэж байжээ.

Эх сурвалж: Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэн тусгах нь: Малайз улсын жишээ, туршлага.

1. ҮНО - Хаана үйлдвэрлэгдсэнээс нь шалтгаалахгүйгээр тухайн улсын эдийн засгийн харьяатуудын эзэмшиж байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн орлогын нийлбэр үзүүлэлт юм.

БҮЛЭГ 2. УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДААГ ШАЛГАХ, НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙ

2.1. Хөгжлийн бодлогын уялдааг шалгах, нөлөөллийг үнэлэх ерөнхий арга зүй

Бодлогын уялдааг шинжихэд ашиглах үндсэн шалгуур нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хувьд дэвшүүлсэн бодлогын зорилго, зорилтууд байх бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төлөвлөгөөнүүдийн хувьд тодорхой төлөвлөсөн үйл ажиллагаа, ажил, арга хэмжээнүүд юм.

Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д “бодлогын зорилт” гэж “асуудлыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэхэд чиглэсэн Засгийн газраас аливаа бодлогын хүрээнд дэвшүүлсэн оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг ойлгоно” гэж томъёолжээ.

Хөгжлийн бодлогын уялдааг шалгах, нөлөөллийг үнэлэх арга зүй нь доорх 2 үе шаттай байна.

1. Сонгосон хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд бидний сонирхож буй бодлогын зорилтууд тусгагдсан байдлыг үнэлнэ. Энэ шатанд тухайлбал, ДТХЗ-ууд Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030 (МУТХҮБ-2030)-д ямар хэмжээтэй тусгагдсан, ямар зорилтууд нь огт тусгагдаагүй, эсвэл салбарын бодлогод тусгагдсан зорилтууд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т ямар хэмжээтэй тусгагдсан зэргийг үнэлж дүгнэнэ.
2. Хөгжлийн аль нэг бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх нь бодлогын бусад зорилтуудад хэрхэн нөлөөлөхийг үнэлнэ. Энэ шат нь аль нэг бодлогын зорилтыг хэрэгжүүлсэн нөхцөлд бодлогын өөр баримт бичгийн зорилтуудад ямар нөлөө үзүүлэхийг оноогоор үнэлэхэд чиглэнэ. Тухайлбал, төрөөс салбарын хөгжлийн талаар баримтлах бодлогын тодорхой хэсгүүд, зорилтууд МУТХҮБ-2030-ын хэрэгжилтэд ихээхэн нөлөөтэй гэж онооны дүнгээр гарвал тэдгээрийг дунд хугацаанд бодлогын тэргүүлэх чиглэлд сонгон авах үндэслэл болно.

Хэрэглэх гол арга нь чанарын өгөгдлийг эмхэлж, цэгцлэх матрицын шинжилгээний арга юм. Матриц нь мөр, баганаас бүрдэнэ. Матриц нь тоон мэдээллийн шинжилгээний хүснэгттэй төстэй боловч өгөгдөл нь тоон биш өгүүлбэрийн хэлбэртэй байдаг.

Матрицын арга нь чанарын өгөгдлийг илэрхийлэх хоёр хувьсагч авч нэгийг нь түүний мөрөнд, нөгөөг нь баганад байрлуулж, тэдгээрийн уялдаа холбоог харуулах зорилготой чанарын өгөгдлийг эмхэлж, цэгцлэх ажилбар юм.² Матрицын арга нь сэдэвчилсэн шинжилгээг хийхэд их тохиромжтой байдаг. Бид хөгжлийн бодлогын уялдаа, залгамж чанарыг судлахад энэхүү аргыг ашиглана.

Бодлогын зорилтуудын хоорондын уялдаа болон үзүүлэх нөлөөг шинжлэх, бодлогын тэргүүлэх зорилтуудыг тодорхойлоход энгийн харилцан нөлөөллийн матрицыг ашиглана.

2 Matthew B. Miles & A. Michael Huberman (1994) *Qualitative data analysis: an expanded sourcebook (second edition)*, p.27.

Энэхүү аргыг Швед Улсын Стокгольмын байгаль орчны хүрээлэнгийн эрдэмтэд³ ДТХЗ-ын хоорондын уялдааг шинжлэх, тэргүүлэх зорилтуудыг тодорхойлоход ашигласан. Энэ тохиолдолд эхний түвшний шууд нөлөөний зэрэгцээ 2 дахь түвшний буюу зорилтууд цаашаа өөр нэг зорилтод давхар үзүүлсэн нөлөөгөөр онооны дүнг тооцож болно. Үүнийг тусгай программ ашиглан тооцоолдог.

Бид энэхүү аргыг арай хялбарчлан өөрийн орны нөхцөлд тохируулан өөрчилж ашиглахаар сонгосон. Матрицын багана болон мөрүүдэд хоорондын уялдаа, нөлөөллийг нь шинжилж байгаа бодлогын зорилтуудыг байрлуулна. Ингэхдээ, дээрх институцийн судлаачдын боловсруулсан арга зүйг ашигласан Хүснэгт 1-т харуулсан 7 түвшинтэй оноог зэрэг болон сөрөг нөлөөллийн хүчийг хэмжихээр авна.

Хүснэгт 1. Бодлогын зорилтуудын хоорондын уялдаа, нөлөөг тодорхойлох оноо

Оноо	Онооны утга агуулга
+3	Харьцуулж буй зорилтын хэрэгжилтэд шууд хүчтэй нөлөөтэй, шууд хүчтэй уялдаатай.
+2	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд тус болно.
+1	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх нөхцлийг яваандаа бүрдүүлнэ.
0	Эерэг болон сөрөг ямар нэг нөлөө үзүүлэхгүй.
-1	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх сонголтуудыг хязгаарлана.
-2	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлнө.
-3	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй болгоно, хүчтэй эсрэг нөлөөтэй.

Эх сурвалж: Nina Weitz, Hencik Carlsen, Mans Nisson Kristain Skanberg , Toward systematic and contextual priority setting for implementation the 2030 Agenda, 2017.

Дээрх хүрээлэнгийн судлаачид ДТХЗ-ын зарим зорилтуудын хоорондын уялдааг хэрхэн дүгнэснийг жишээ болгон авч үзье. Тухайлбал ДТХЗ-ын дэд бүтцийг хөгжүүлэх тухай 9,1 гэсэн зорилтыг хэрэгжүүлснээр ДТХЗ-ын экосистемийн унаган төрхийг хадгалан алдагдуулахгүй байх 15,1 гэсэн зорилтыг үгүйсгэж, түүнд эсрэгээр нөлөөлнө гэж үзэж, -3 гэсэн оноог өгсөн байна. Харин ДТХЗ-ын агаарын бохирдлыг бууруулах 12,4 гэсэн зорилтыг хэрэгжүүлснээр хүн амын эрүүл мэндийг сайжруулах, халдварт бус өвчний гаралтыг бууруулах талаарх 3,4 гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд хүчтэй шууд нөлөөлөх тул + 3 гэсэн оноог өгсөн байна.

Зөвхөн нэг тодорхой баримт бичгийн доторх бодлогын зорилтуудын уялдааг харуулахад Швед улсын дээр дурдсан эрдэмтэд илүү анхаарсан бөгөөд салбарын болон үндэсний хэмжээний гэх мэт өөр өөр түвшний бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудын уялдааг шинжлэхэд энэ аргыг одоогоор хэрэглээгүй, ийм оролдлого хийгээгүй байсан. Бидний хувьд өөр өөр бодлогын баримт бичгүүдийн уялдааг шинжлэхэд энэхүү аргыг хэрэглэхээр туршиж үзсэн нь шинэлэг хандлага болсон. Бодлогын өөр өөр баримт бичгүүдийн уялдааг шинжлэхэд багана, мөрийн огтлолцол нүдэнд оноог нөхнө. Энд мөрөнд тавигдсан зорилтууд баганад тавигдсан зорилтууддаа хэрхэн нөлөөлж байгааг оноогоор үнэлдэг. Энэ нь илүү хялбар ойлгомжтой байдаг. Энэхүү арга зүйг доор тодорхой жишээн дээр харуулсан.

Хөгжлийн бодлогын уялдааг шалгахын тулд нэг баримт бичигт туссан бодлого

3. Nina Weitz, Hencik Carlsen, Mans Nisson Kristain Skanberg, "Toward systematic and contextual priority setting for implementation the 2030 Agenda", 2017.

нөгөө баримт бичигт тусгагдсан эсэхийг үнэлэхдээ 3-4 төрлийн ангиллыг ашигласан. Тухайлбал, ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын уялдааг хянахдаа тухайн бодлого тусгагдсан байдлыг илэрхийлэх доорх 4 түвшний ангиллыг ашигласан. Үүнд:

1. Шууд тусгагдсан
2. Агуулгын хувьд уялдсан
3. Огт тусгагдаагүй
4. Манай оронд хамааралгүй

Харин МУТХҮБ-2030 болон салбарын хөгжлийн бодлогын уялдааг шалгахдаа дээрх ангиллын эхний 3 түвшинг ашигласан.

Үүний зэрэгцээ 7 түвшний оноог нэгтгэн дүгнэсний дараах үр дүнд үнэлгээ хийхдээ онооны боломжит дээд хэмжээнд эзлэх хувийг тооцож, доорх 5 бүлэгт ангилна. Үүнд:

1. 20 хүртэлх хувьтай бол хамааралгүй, нөлөө маш багатай
2. 21-40 хувь бол сулхан нөлөөтэй
3. 41-60 хувь бол дунд зэргийн нөлөөтэй
4. 61-80 хувь бол дундаас дээгүүр нөлөөтэй
5. 81-100 хувь бол хүчтэй хамаарал, нөлөөтэй

Энд онооны боломжит дээд хэмжээ гэдгийг доорх жишээгээр ойлгоно. Аль нэг бодлогын тодорхой нэг зорилтыг бодлогын өөр баримт бичгийн зорилтуудад хэрхэн нөлөөлөхийг шинжиж байгаа тохиолдолд зорилтын тоог 7 түвшний онооны дээд түвшин болох 3-аар үржүүлж боломжит дээд хэмжээг тогтооно. Жишээлбэл, нэг тодорхой зорилтыг өөр баримт бичгийн 9 зорилтод үзүүлэх нөлөөллийг шинжилж байгаа үед онооны дээд хэмжээ 27 ($9 \times 3 = 27$) болно. Энэ тохиолдолд тухайн нэг зорилтын мөрийн дүнгээр онооны нийлбэр 12 гарсан бол онооны боломжит дээд хэмжээнд эзлэх хувь 44,4% ($12/27 = 0,444$) болж, тухайн зорилтыг хэрэгжүүлэх нь нөгөө баримт бичгийн 9 зорилтын хэрэгжилтэд дунд зэргийн нөлөө үзүүлэхээр үнэлэгдэнэ гэсэн үг юм.

Бид дээр авч үзсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нийтлэг арга зүй, зарчимд тулгуурлан урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдааг доорх 4 чиглэлээр шалгаж, үнэлгээ өгнө. Үүнд:

Чиглэл 1: Эхний шатанд ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтууд хоорондоо хэрхэн уялдсан байдлыг үнэлнэ. Үнэлгээ нь дээр дурдсанаар дотроо 2 үе шаттай байна. Эхний үе шатанд ДТХЗ-д тодорхойлсон бодлогын зорилтууд МУТХҮБ-2030-д хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлгээ өгнө. Хоёрдах шатанд МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтууд ДТХЗ-ын хэрэгжилтэд хэрхэн нөлөөлөх байдлыг үнэлнэ.

Энэ чиглэлээр эхний үе шатны үнэлгээг Үндэсний хөгжлийн газарт (ҮХГ)-т хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийсэн тул салбарын яамдууд хийх шаардлагагүй, харин өгсөн үнэлгээнд саналаа өгч болно. Доор тусгайлан харуулсан матрицуудыг ашиглан ДТХЗ-д тодорхойлсон бодлогын зорилтууд МУТХҮБ-2030-д шууд тусгагдсан, агуулгын хувьд уялдаж байгаа, огт тусгагдаагүй, манай орны хувьд хамааралгүй гэсэн 4 ангиллаар ялгах замаар тусгагдсан байдалд үнэлгээ өгнө. Шууд уялдсан зорилтуудын хувьд нэмэлт байдлаар хэмжих шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн хүрэх түвшинг давхар харгалзан үзнэ.

Чиглэл 2: МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд салбар, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хэрхэн тусгагдсан болон уялдсан байдлыг шалгаж, үнэлгээ өгнө. Үнэлгээ нь дээр дурдсанаар дотроо 2 үе шаттай хийгдэнэ.

Манай орны хувьд 2016 оноос өмнө батлагдсан төрөөс баримтлах салбарын

бодлогууд, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь МУТХҮБ-2030-тай сайн уялдаагүй байгаа бөгөөд цаг хугацааны хувьд өмнө батлагдсан тул шууд тусгах боломжгүй байгаа тал зарим салбарын бодлогын баримт бичигт хийсэн үнэлгээний явцад ажиглагдсан.

Чиглэл 3: Салбарын дунд хугацааны бодлогын хэд хэдэн баримт бичигтэй тохиолдолд тэдгээр нь өөр хоорондоо хэрхэн уялдсан, өөр цаг хугацаанд батлагдсан салбарын бодлогын баримт бичгүүдийн залгамж чанар нь хадгалагдсан эсэхийг үнэлнэ. Үнэлгээ нь мөн дээр дурдсанаар дотроо 2 үе шаттай хийгдэнэ.

Чиглэл 4: Үндэсний болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, яам, агентлагуудын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги, төлөвлөгөөнүүдэд хэрхэн тусгагдсаныг нэг бүрчлэн шалгаж, үнэлгээ хийнэ.

Энэ үе шатны гол зорилго нь "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр" үндэсний хэмжээний болон салбарын хөгжлийг тодорхойлсон бодлогуудтай хэрхэн уялдсан байдлыг тогтоож, үнэлгээ өгөхөд оршино.

2.2. Чиглэл тус бүрээр бодлогын уялдааг шалгах, үнэлэх арга зүй

Чиглэл 1. ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтууд хэрхэн уялдсан байдлыг үнэлэх арга зүй.

Үнэлгээ нь ерөнхий арга зүйд дурдсанаар дотроо 2 үе шаттай байна.

I үе шат: ДТХЗ-д тодорхойлсон бодлогын зорилтууд МУТХҮБ-2030-д хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлгээ өгөх арга зүй

ДТХЗ-ууд МУТХҮБ-2030-д хэрхэн тусгагдсаныг доорх Загвар матриц 1-ыг ашиглан ДТХЗ-ын 169 зорилт бүрд ерөнхий арга зүйд дурдсан 4 ангиллаар МУТХҮБ-2030-д тусгагдсан байдлаар нь үнэлгээ өгч дүгнэнэ. Энэхүү матриц нь нүсэр том, үндсэндээ ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтуудыг зэрэгцүүлэн харуулсан хүснэгт болох тул Excel дээр файл үүсгэх нь илүү зохимжтой байх болно. Практикт холбогдох мэргэжилтнүүд ДТХЗ-ын 17 зорилгын 169 зорилтыг хуваан авч матрицаа хэсэгчлэн задлах нь илүү тохиромжтой хялбар байх болно. МУТХҮБ-2030-ын хувьд хөгжлийн бодлогын зарим чухал асуудлыг бодлогын зорилт болгон тодорхойлоогүй, харин зарчим болгон томьёолсон тал байгаа. Иймд тэдгээрийг энэхүү матрицад харуулаагүй, зарчим бол дэвшүүлсэн зорилт биш, харин баримтлах гол чиглэл болно. Тухайлбал, ДТХЗ-ын 5 дахь зорилго нь жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх талаар 9 зорилтыг дэвшүүлсэн бол МУТХҮБ-2030-д энэ асуудал нийгмийн хөгжлийн бодлогын зарчим гэсэн хэсэгт ганц товч өгүүлбэрээр орсон байх жишээтэй.

Загвар матриц 1. ДТХЗ-д тодорхойлсон бодлогын зорилтууд МУТХҮБ-2030-д хэрхэн тусгагдсаныг хянах матриц

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй, 4-манай оронд хамааралгүй
Доош нь 17 зорилгын хүрээнд 169 зорилтыг нэг бүрчлэн харуулна.	Монгол Улсын 44 зорилтоос гадна зарчим гэсэн хэсэгт орсон хэсгүүдээс холбогдох байдлаар нь зэрэгцүүлэн харуулна.	Дээрх 4 ангиллын аль тохирох тоон тэмдэглэгээг тавина.

Шууд тусгагдсан гэдэг үнэлгээг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтын агуулга яг давхцаж байгаа тохиолдолд өгнө. Агуулгын хувьд уялдсан гэдэгт зорилтын агуулгын зарим хэсгүүд тусгагдсан, эсвэл арай өөр хэлбэрээр илэрхийлсэн боловч агуулгын хувьд нийцсэн зорилтуудыг хамруулна.

Сүүлийн баганад Монгол Улсын тодорхойлсон зорилтууд ДТХЗ-тай хэрхэн уялдаж байгааг дээр харуулсан 1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй, 4-манай оронд хамааралгүй гэсэн 4 ангиллаар үнэлж дүгнэнэ. Бид хялбарчлах үүднээс ДТХЗ-ын эхний Зорилго 1-ийн зорилтууд МУТХҮБ-2030-д хэрхэн тусгагдсаныг доорх Загвар матриц 2-д 4 ангиллаар үнэлж харуулав.

Загвар матриц 2. ДТХЗ-д тодорхойлсон бодлогын сонгосон зорилтууд МУТХҮБ-2030-д хэрхэн тусгагдсан байдлын үнэлгээ

№	Зорилтууд	Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгууд	Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал-2030	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй, 4-манай оронд хамаарахгүй
Зорилго 1. Ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах				
1	1.1.	2030 он гэхэд нэн ядуурлыг бүрэн устгах. Нэн ядууралд өдөрт 1.25 ам.доллараар амьдарч буй хүмүүс хамрагдана.	Зорилт 1. Ядуурлыг бүх төрлийг эцэс болгоно.	1
2	1.2.	Үндэсний үзүүлэлтээр ядуурлын түвшинд амьдарч байгаа бүх эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн тоог тэн хагасаас доошгүй хувиар бууруулах	1-р үе шат (2016-2020): Ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах. 2-р үе шат (2021-2025): Иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулан тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулж, нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх.	1
3	1.3.	Амьжиргааны доод хэмжээг тогтоох зэрэг бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоо болон арга хэмжээг үндэсний нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх, 2030 он гэхэд ядуу болон эмзэг бүлгийнхнийг хамруулахад дорвитой ахиц гаргах.	Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулан хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2
4	1.4.	2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүмүүс, ялангуяа, ядуу болон эмзэг бүлгийнхэн эдийн засгийн нөөцийг ашиглах, холбогдох шинэ технологи болон санхүүгийн, бичил санхүүгийн үйлчилгээнд хамрагдах тэгш эрхийг хангана.	Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхиүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгон, бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.	2

БҮЛЭГ 2. УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДААГ ШАЛГАХ, НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙ

5	1.5.	2030 он гэхэд ядуу, эмзэг байдалд байгаа хүмүүсийн уян хатан байдлыг бэхжүүлэх, уур амьсгалын холбоотой онцгой нөхцөл, эдийн засаг, нийгэм, байгаль орчны гамшиг, аюулд өртөх эмзэг байдлыг бууруулах.	3
6	1.а.	Хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй орнуудад ядуурлын бүх хэлбэрийг устгах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хангалттай, найдвартай арга хэрэгслийг янз бүрийн эх сурвалжаас ихээхэн нөөцийг дайчлах, хөгжлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хангах.	3
7	1.б.	Ядуурлыг устгахад оруулах хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн, ядуус, жендэрийн эмзэг асуудлыг харгалзсан зохистой бодлогын тогтолцоог үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд бий болгох.	3

Хүснэгт 2. ДТХЗ-д тодорхойлсон бодлогын бүх зорилтууд МУТХҮБ-2030-д тусгагдсан байдал

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд		Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын зорилтууд			
Зорилгууд	Зорилтууд	Шууд тусгагдсан	Агуулгын хувьд уялдсан	Огт тусгагдаагүй	Манай оронд хамаарахгүй
Зорилго 1	7	2	2	3	0
Зорилго 2	8	0	5	3	0
Зорилго 3	13	4	4	5	0
Зорилго 4	10	3	2	5	0
Зорилго 5	9	0	0	9	0
Зорилго 6	8	3	1	4	0
Зорилго 7	5	2	2	1	0
Зорилго 8	12	4	1	7	0
Зорилго 9	8	3	1	4	0
Зорилго 10	10	1	4	5	0
Зорилго 11	10	3	5	2	0
Зорилго 12	11	1	5	4	1
Зорилго 13	5	3	0	2	0
Зорилго 14	10	0	0	0	10
Зорилго 15	12	2	1	9	0
Зорилго 16	12	1	2	8	1

Зорилго 17	19	4	6	5	4
Зорилтуудын нийт дүн	169	36	41	76	16
Дүнд эзлэх хувь	100	21.3	24.3	45	9.5

Эх сурвалж: ҮХГ-ын ХБТГ-ын тооцоолол.

ДТХЗ-ын нийт зорилтуудын 21,3 хувь нь МУТХҮБ-2030-д шууд тусгагдсан, 24,3 хувь нь агуулгын хувьд уялдсан, харин 45 хувь нь огт тусгагдаагүй гэсэн үнэлгээ гарч байна.

МУТХҮБ-2030 нь ДТХЗ-ын нийт зорилтуудын 45 хувийг огт тусгаагүй тул ДТХЗ-ыг МУТХҮБ-2030-д хангалттай сайн суулгаж өгөөгүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Ялангуяа жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх талаарх Зорилго 5-д тусгагдсан 9 заалт МУТХҮБ-2030-д тодорхой зорилт болгон тусгагдаагүй байгаа нь анхаарал татаж байна. Нийгмийн хөгжлийн зорилтууд дотор ганц өгүүлбэр зарчим гэсэн хэсэгт орсон нь огт хангалтгүй юм. Түүнчлэн хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийт хүн амыг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах Зорилго 8-ын нийт 12 зорилтын 7 нь буюу 58 хувь нь, экологийн системийг хамгаалах талаарх Зорилго 15-ын нийт 12 зорилтын 9 буюу 3/4 нь, хууль ёст тогтвортой хөгжлийн нийгмийг бүрдүүлж, үр нөлөөтэй институцийг бүх шатанд бий болгох талаарх Зорилго 16-ын нийт 12 зорилтын 8 буюу 2/3 нь тодорхой тусгагдаагүй байна.

II үе шат: ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтууд хоорондоо хэрхэн уялдсан ба тэдгээрийн харилцан нөлөөлөх байдлыг үнэлэх арга зүй.

I үе шатны үнэлгээнээс харахад ДТХЗ-ын 169 зорилтын 76 нь МУТХҮБ-2030-д огт тусгагдаагүй тул ДТХЗ-ын хэрэгжилтэд МУТХҮБ-2030-ын зорилтуудын нийт дүнгээрээ үзүүлэх нөлөө төдийлөн их биш байж болох талтай. Гэхдээ эдгээр бодлогын зорилтуудын өөр хоорондын хамаарлыг Загвар матриц 2-ын тусламжтайгаар хэрхэн үнэлэхийг доор харуулав. Доорх энгийн харилцан нөлөөлийн матрицын мөрүүдэд ДТХЗ-ын ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах Зорилго 1-ийн 5 зорилтыг, багануудад МУТХҮБ-2030-ын эдийн засгийн тогтвортой хөгжлийн хэсгийн 3 тэргүүлэх салбарт дэвшүүлсэн нийт 9 зорилтыг дугаараар нь байрлуулсан. ДТХЗ-ын бүх 169 зорилт болон МУТХҮБ-2030-ын бүх зорилтуудыг энд бүрэн харуулах боломжгүй тул сонгосон хэсгийг жишээ болгон харуулав. ДТХЗ-ын ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах Зорилго 1-ийн 5 зорилтыг доор харуулав.

Зорилго 1. Ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах

1. 2030 он гэхэд нэн ядуурлыг бүрэн устгах. Нэн ядууралд өдөрт 1,25 доллараар амьдарч байгаа хүмүүс хамрагдана.
2. Үндэсний үзүүлэлтээр ядуурлын түвшинд амьдарч байгаа бүх насны эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн тоог тэн хагасаас доошгүй хувиар бууруулах.
3. Амьжиргааны доод хэмжээг тогтоох зэрэг бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоо болон арга хэмжээг үндэсний нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх, 2030 он гэхэд ядуу болон эмзэг бүлгийнхнийг хамруулахад дорвитой ахиц гаргах.
4. 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүмүүс, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийнхэн эдийн засгийн нөөцийг ашиглах, үндсэн үйлчилгээнд хамрагдах,

газар болон бусад өмчийн хэлбэрийг өмчлөх, түүнд хяналт тавих, залгамжлах, байгалийн нөөцийг ашиглах, холбогдох шинэ технологи болон санхүүгийн, бичил санхүүгийн үйлчилгээнд хамрагдах тэгш эрхийг хангана.

- 2030 он гэхэд ядуу, эмзэг байдалд байгаа хүмүүсийн уян хатан байдлыг бэхжүүлэх, уур амьсгалын холбоотой онцгой нөхцөл, эдийн засаг, нийгэм, байгаль орчны гамшиг, аюулд өртөх эмзэг байдлыг бууруулах.

МУТХҮБ-2030-ын эдийн засгийн тогтвортой хөгжлийн хэсгийн 3 тэргүүлэх салбарт дэвшүүлсэн нийт 9 зорилтыг доор харуулав.

Хүснэгт 3. МУТХҮБ-2030-ын сонгосон зорилтууд

2.1.1. Хөдөө аж ахуйн салбар			
Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бий бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.	Зорилт 2. Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.	Зорилт 3. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.	Зорилт 4. Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр ханган, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.
2.1.2. Аялал жуулчлалын салбар			
Зорилт 1. Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.			
2.1.3. Аж үйлдвэрийн салбар			
Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.	Зорилт 2. Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт тенгологи нэвтрүүлж, өрсөлдөх чавдарыг дээшлүүлэн, гол нэр, төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Зорилт 3. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.	Зорилт 4. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр, төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.

Эх сурвалж: МУТХҮБ-2030.

Сонгосон бодлогын зорилтуудыг матрицад байрлуулахдаа мөрүүдэд нь нөлөөлөгч хүчин зүйлд хамаарах зорилтуудыг, харин багануудад нь түүнээс хамаарах нөлөөллийн үр дүнг нь сонирхож байгаа зорилтуудыг байрлуулна. Бидний хувьд ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтууд хоорондоо хэрхэн уялдсан, харилцан нөлөөлөх байдлыг үнэлэх гэж байгаа тул нэн тэргүүнд МУТХҮБ-2030-ын зорилтууд ДТХЗ-ын хэрэгжилтэд хэрхэн нөлөөлөхийг авч үзэх нь чухал юм. Нөгөө талаасаа мөр, багануудын зорилтуудын байрыг сольж, ДТХЗ-ыг хэрэгжүүлснээр МУТХҮБ-2030-ын зорилтууд ямар нөлөөтэй байхыг үнэлж болно.

Оноог тавихдаа тухайн мөрөнд байгаа бодлогын зорилт хэрэгжсэн нөхцөлд багануудад байгаа зорилтуудад яаж нөлөөлөхийг дээр ерөнхий арга зүйд харуулсан 7 түвшний онооноос аль тохирохоор нь үнэлж тавина. Өөрөөр хэлбэл, доорх хүснэгтэд сумаар дүрслэн харуулснаар зүүн гар талаас баруун тийш нь мөр бүрээр оноог байрлуулж, төгсгөлийн багананд нийлбэрийг дүгнэж харуулна.

Хүснэгт 4. Нөлөөллийг үнэлэх матрицын ерөнхий загвар

Зорилтууд		Үр дүнгийн хувьсагч			
		Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Дүн
Нөлөөлөгч хүчин зүйл	Зорилт 1				
	Зорилт 2				
	Зорилт 3				

Доор харуулсан 9x5 харьцаатай Загвар матриц 3-аар МУТХҮБ-2030-ын сонгосон зорилтууд ДТХЗ-ын Зорилго 1-д хэрхэн нөлөөлөхийг оноогоор үнэлж, үнэлгээ өгсөн байдлыг үзүүлэв.

Загвар матриц 3. МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилт ДТХЗ-ын Зорилго 1-д үзүүлэх нөлөөг оноогоор үнэлэх жишээ

МУТХҮБ-2030-ын зорилтууд 1.1		ДТХЗ: Зорилго 1-ийн 5 зорилтууд					Дүн	Онооны үнэлгээ (хувь)
		1.1	1.2	1.3	1.4	1.5		
Хөдөө аж ахуй	Зорилт 1	3	3	0	0	0	6	40
	Зорилт 2	1	1	0	0	0	2	13
	Зорилт 3	1	1	0	0	0	2	13
	Зорилт 4	1	1	0	0	0	2	13
Аялал жуулчлал Зорилт 1		1	1	0	0	0	2	13
Аж үйлдвэр	Зорилт 1	1	1	0	0	0	2	13
	Зорилт 2	2	2	0	0	0	4	26
	Зорилт 3	1	1	0	0	0	2	13
	Зорилт 4	1	1	0	0	0	2	13
Дүн		12	12	0	0	0	24	18

Мөр, багануудын огтлолцол нүдэнд оноог тавихдаа мөрөнд байгаа зорилтыг хэрэгжүүлснээр багананд байгаа зорилтын хэрэгжилтэд яаж нөлөөлөхийг бодож, үнэлж оноог сонгоно. Жишээлбэл, эхний мөрөнд Хөдөө аж ахуй (ХАА)-н салбарын Зорилт 1-ийг байршуулсан тул “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын

удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуй (МАЗ) салбарыг хөгжүүлнэ” гэсэн Зорилт 1 нь ядуурлын бүх хэлбэрийг устгах талаарх ДТХЗ-ын Зорилго 1-ийн Зорилт 1-ийн хэрэгжилтэд шууд хүчтэй нөлөө үзүүлнэ гэж үзэж 3 оноо өгсөн байна. Энэ Зорилт 1 нь цаашлаад ДТХЗ-ын Зорилго 1-ийн “Үндэсний үзүүлэлтээр ядуурлын түвшинд амьдарч байгаа бүх насны эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн тоог тэн хагасаас доошгүй хувиар бууруулах” гэсэн Зорилт 2-т мөн хүчтэй шууд нөлөөг үзүүлнэ гэж үзэж 3 оноо өгсөн байна. Харин ХАА-н үлдсэн зорилтууд ДТХЗ-ын Зорилго 1-ийн 1.1 болон 1.2 дугаартай зорилтуудыг хэрэгжүүлэх нөхцөлийг яваандаа бүрдүүлнэ гэж үзсэн тул тус бүр 1 оноо өгсөн байна.

Энэ оноог хэн яаж өгөх вэ? гэдэг асуулт тавигдана. Үүний тулд төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан хэлэлцүүлэг явуулж оноог тогтооно. Мөн өмнө хийгдсэн судалгаа шинжилгээний ажлуудын үр дүнг ашиглавал бүр сайн. Бид энэ жишээнд МАЗ-н салбарыг хөгжүүлэх нь ядуурлыг эцэс болгоход шууд нөлөөтэй гэж +3 оноо өгсөн. Олон жилийн ажиглалтаар ган, зуд тохиолдож, мал аж ахуйд хохирол учрахад малчид малгүй болж, хөдөөд ядуучуудын эгнээ нэмэгдэж, малгүй болсон иргэд хот суурин бараадан шилжин ирж, хотын ядуусын тоог нэмэгдүүлсээр ирсэн. Энэ хоёр үйл явдал ийнхүү хоорондоо шууд холбоотой өрнөж ирсэн байдаг. Нөгөө талаасаа мал аж ахуйн салбар нь ажлын байрыг нэмэгдүүлэх хамгийн чухал салбар тул ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад их нөлөөтэй юм.

Одоо мөр, багануудын онооны нийлбэр дүнг хэрхэн тайлбарлахыг авч үзье. Эхний мөрөнд МУТХҮБ-2030-ын ХАА-н салбарын Зорилт 1-ийг байрлуулсан. Энэхүү зорилтыг хэрэгжүүлснээр ДТХЗ-ын Зорилго 1-ийн 1.1 болон 1.2 дугаартай зорилтуудыг хэрэгжүүлэх маш хүчтэй шууд нөлөөтэй гэж тус бүр +3 оноо өгсөн тул нийлбэр дүн нь баруун гар талын дүнгийн баганад 6 болсон бөгөөд МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилт дотроос хамгийн өндөр оноо болж байна. Дараагийн өндөр оноо нь аж үйлдвэрийн салбарын Зорилт 2-ын нөлөөллийн нийлбэр дүн 4 юм. Хамгийн өндөр оноотой мөрөнд тавигдсан бодлогын зорилт бусаддаа хүчтэй нөлөөтэй гэж үзэж, тэргүүлэх зорилтод сонгогдоно.

Одоо баганын дүнг авч үзье. Эхний баганад ДТХЗ-ын Зорилго 1-ийн Зорилт 1 байгаа билээ. Энэ баганын дүн 12 оноотой гарсан бөгөөд энэ нь МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилтын ДТХЗ-ын Зорилго 1-ийн Зорилт 1-д үзүүлэх нийлбэр нөлөөг харуулна. Энэ байдлаар багана бүрийн дүн нь МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилтын ДТХЗ-ын Зорилго 1-ийн холбогдох зорилтуудад үзүүлэх нийлбэр нөлөөллийг харуулна.

Одоо онооны үнэлгээг хэрхэн гаргасныг авч үзье. Онооны үнэлгээ нь мөрийн авч болох дээд оноонд эзлэх хувийг харуулж байгаа болно. Жишээлбэл, эхний мөрийн 40 гэсэн хувийг хэрхэн гаргасныг авч үзье. Энэхүү матрицад 5 багана байгаа. Мөрийн дүнгийн авч болох дээд оноо бол 5 баганын хувьд тус бүр 3 гэж үзээд 15 оноо болно. Эхний мөрийн нийлбэр оноо 6 байгаа нь авч болох дээд онооны 40 хувь ($6/15=0,4$) болсныг харуулж байна.

Хоёр дахь мөрний онооны нийлбэр дүн 2 байгаа тул авч болох дээд оноонд эзлэх хувь 13 болж ($2/15=0,1333$) байна.

Одоо матрицын баруун гар талын доод өнцөгт харуулсан 18 хувь нь мөр, багануудын нийлбэр дүн болох 24 онооноос тооцогдох хувь бөгөөд 5×9 хэмжээтэй матрицын авах


дээд оноо болох $5 \times 9 \times 3 = 135$ онооноос тооцогдоно. Өөрөөр хэлбэл, 18 хувь ($24/135 = 0,1777$) нь 135 оноонд 24 онооны эзлэх хувь болно.

Мөрүүд дэх зорилтуудын авч болох дээд оноонд эзлэх хувь харилцан нөлөөллийн харьцангуй түвшинг илэрхийлж байгаа тул аль болох өндөр хувь (ангиллын 81-100 хувь гэсэн бүлэг) авсан бодлогын зорилтыг дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлд сонгон авах үндэслэл болно. Учир нь авч болох дээд оноонд эзлэх хувь өндөр байх нь уг зорилтын бусад зорилтын хэрэгжилтэд үзүүлэх нөлөө хүчтэй гэдгийг илтгэнэ.

Энэхүү аргачлалд бид жишээ болгон ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын зорилтуудын сонгосон хэсгийг харуулсан. Үүнийг бүрэн хэмжээгээр хийх нь нүсэр том хэмжээний матриц үүсгэх тул энд харуулах боломжгүй.

Дээрх хоёр баримт бичгийн зорилтуудын уялдаа холбоог доорх Зураг 2-т дүрслэн харуулав.

Зураг 2. ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын сонгосон зорилтууд хоорондоо уялдсан байдлын зураглал



Эх сурвалж: ҮХГ-ын төслийн баг.

Дээрх бүдүүвч зурагт оноо бүрийг нэг зураасаар дүрсэлсэн бөгөөд зорилт хоорондын аль нь алиндаа нөлөөлөх чиглэлийг сумны заалт харуулна. Энэхүү бүдүүвч нь аль зорилт дээр олон сум төвлөрч байгааг харуулах бөгөөд энэ нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд бусад зорилтууд ихээхэн нөлөөтэйг илтгэнэ. Тухайлбал, МУТХҮБ-2030-ын дээрх Загвар матриц 3-д харуулсан сонгосон 9 зорилт 2030 он гэхэд нэн ядуурлыг бүрэн устгах (1.1.) болон үндэсний үзүүлэлтээр ядуурлын түвшинд амьдарч байгаа бүх насны эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн тоог тэн хагасаас доошгүй хувиар бууруулах (1.2.) зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлэхийг илтгэн харуулж (олон зураас чиглэсэн тул) байна.

Чиглэл 2: МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд салбар, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилтуудтай хэрхэн уялдсан, холбогдсон байдлыг шалгаж, үнэлгээ өгөх арга зүй.

Үнэлгээ нь дээрх ерөнхий арга зүйд дурдсанаар дотроо 2 үе шаттай байна.

I үе шат: ДТХЗ болон МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд салбарын хөгжлийн бодлогод хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлгээ өгөх арга зүй.

Бид эхлээд МУТХҮБ-2030-д тодорхойлсон үндэсний хэмжээний зорилтууд салбарын хөгжлийн бодлогод хэрхэн тусгагдсан байдлыг үнэлэх үнэлгээг Загвар матриц 3-т харуулсан 3 ангиллаар өгнө.

Загвар матриц 4. МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд салбарын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогод тусгагдсан байдал

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Салбарыг хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлого	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй
МУТХҮБ-2030-ын 44 зорилтоос гадна зарчим гэсэн хэсэгт орсон хэсгүүдээс холбогдох байдлаар нь зэрэгцүүлэн харуулна.	Салбарын бодлогын баримт бичигт МУТХҮБ-2030-д холбогдох зорилт, заалт байвал бичнэ.	Дээрх 3 ангиллын аль тохирох тоон тэмдэглэгээг тавина.

Энэхүү матрицыг бүрэн нөхсөнөөр Чиглэл 1-ийн 1-р шатанд хийсэнтэй адил үнэлнэ. Тухайлбал, МУТХҮБ-2030-ын 44 зорилтын хэдэн хувь нь шууд тусгагдсан, хэдэн хувь нь агуулгын хувьд уялдсан, хэдэн хувь нь огт тусгагдаагүйг дүгнэх байдлаар үнэлгээг өгнө.

Бид энд жишээ болгон 2015 онд батлагдсан "Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого" (ТЭХтББ)-ыг авч үзье. Эрчим хүчний салбарт одоогоор бодлогын ганц баримт бичиг хүчин төгөлдөр үйлчилж байна. Зарим салбарын хувьд, жишээлбэл, усны салбарт "Усны үндэсний хөтөлбөр", "Ногоон хөгжлийн бодлого" гэх мэт хэд хэдэн баримт бичиг үйлчилж байгаа тул тус бүрт нь матриц үүсгэн үнэлгээ хийнэ. Доорх матрицад ДТХЗ болон МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд ТЭХтББ-д тусгагдсан эсэхийг харьцуулан шинжлэхийг харуулав. Эрчим хүчний талаар ДТХЗ, МУТХҮБ-2030-д цөөхөн тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн тул давхраар нь харьцуулан шинжлэхэд хялбархан байна. Энд бид үнэлгээг өгөхдөө дээрх 3 ангиллыг ашигласан.

Загвар матриц 5. ДТХЗ, МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд ТЭХтББ-д тусгагдсан байдал

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгууд	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого	Үнэлгээ
Зорилго 7. Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчээр хангах	Зорилт 1. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.		
Зорилт 7.1. 2030 он гэхэд нийт хүн амыг хямд, найдвартай, орчин үеийн эрчим хүчээр хангах.	2026-2030 онд эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүчний экспортлогч орон болох.		3

<p>Зорилт 7.2. 2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний тогтолцоонд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг үлэмж нэмэгдүүлэх.</p>	<p>III үе шат (2026-2030): Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглаж эхлэх.</p>	<p>3.1.6. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах. 3.2.2.3. Монгол орны говийн бүсийн нар, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбороос Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачилгыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах;</p>	<p align="center">1</p>
<p>Зорилт 7.3. 2030 он гэхэд эрчим хүч ашиглалтын үр ашгийг дэлхийн хэмжээнд хоёр дахин өсгөх.</p>			<p align="center">3</p>
<p>Зорилт 7.а. 2030 он гэхэд экологийн цэвэр эрчим хүчний эрдэм шинжилгээ болон технологийг хангах явдлыг эрчимжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, цэвэр ашигт малтмалын шатахууны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, эрчим хүчний дэд бүтэц болон цэвэр эрчим хүчний технологид хөрөнгө оруулалтыг дэмжих.</p>			<p align="center">3</p>
<p>Зорилт 7.б. 2030 он гэхэд, хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй орнууд, далайд гарцгүй хөгжиж байгаа орнууд, арлын хөгжиж байгаа жижиг орнуудын нийт хүн амыг орчин үеийн, тогтвортой эрчим хүчний үйлчилгээгээр хангах зорилгоор холбогдох дэмжлэгийн хүрээнд дэд бүтцийг өргөжүүлэх, технологийг шинэчлэх.</p>			<p align="center">3</p>

Загвар матриц 5-аас харахад ДТХЗ-ын Зорилго 7 болон Зорилт 7.1-тэй холбогдохоор заалтууд МУТХҮБ-2030-д тусгагдсан боловч ДТХЗ-ыг шууд тусгасан гэж үнэлэхээргүй, зөвхөн агуулгын хувьд уялдаатай гэж үзэж болохоор байна. Учир нь нийт хүн амыг эрчим хүчээр хангах болон эрчим хүчнийхээ хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр бүрэн хангах зорилтууд ялгаатай билээ. Харин ДТХЗ-ын Зорилт 7.3-ын хувьд МУТХҮБ-2030-д тусгагдсан сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилттой шууд нийцэж байна. Энэ зорилт ТЭХТББ-ын 3.1.6 болон 3.2.2.3 дахь заалтуудтай шууд холбогдож

байгаа болно. Эндээс харахад ТЭХтББ-д тусгагдсан нэг зорилт үндсэндээ ДТХЗ болон МУТХҮБ-2030-д тусгагдсан байна. ТЭХтББ-ын хүрээнд дэвшүүлсэн олон зорилт байгаа бөгөөд тэдгээр нь ДТХЗ болон МУТХҮБ-2030-д ямар нөлөөтэй болохыг доор тусад нь авч үзлээ. Энд бид бодлогын баримт бичгүүд өөр өөр цаг хугацаанд хийгдсэн, тухайлбал, ТЭХтББ 2015 оны 6 сард буюу ДТХЗ болон МУТХҮБ-2030 батлагдахаас өмнө гарсан тул дээрх 2 баримт бичигтэй шууд уялдах боломжгүй байсныг харгалзан үзэх ёстой.

II үе шат: МУТХҮБ-2030-ын зорилтууд болон салбарын хөгжлийн бодлогын харилцан уялдаа ба нөлөөлөх байдлыг оноогоор үнэлэх арга зүй

Энд бид жишээ болгон зөвхөн МУТХҮБ-2030-ын зорилтууд эрчим хүчний салбарын хөгжлийн бодлоготой хэрхэн уялдсан байдлыг үнэлэх арга зүйг авч үзье. ТЭХтББ нь 3 тэргүүлэх гол чиглэлээр 6 гол зорилгыг дэвшүүлсэн ажээ. Эдгээр 6 зорилгыг цааш нь задалж, нийтдээ 27 зорилтыг (хаалтанд зорилтуудын тоог харуулав) дэвшүүлсэн байна.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын үндсэн 6 зорилго:

Тэргүүлэх чиглэл 1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах

- 1.1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах (6);
- 1.2. Бүс нутгийн орнуудтай эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх (4);
- 1.3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах (3).

Тэргүүлэх чиглэл 2. Эрчим хүчний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх.

- 2.1. Эрчим хүчний салбарыг хувийн хэвшилд суурилсан, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх (3);
- 2.2. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх (5).

Тэргүүлэх чиглэл 3. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих.

- 3.1. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах (6).

Бид бодлогын уялдааг 6 гол зорилгын хүрээнд энгийн харилцан нөлөөллийн матриц байгуулах аргаар авч үзлээ. Матрицын багануудад ТЭХтББ-ын 3 тэргүүлэх гол чиглэлээр 6 гол зорилгын дугаарыг байрлуулсан. Матрицын багануудад МУТХҮБ-2030-ын ХАА, Аялал жуулчлал болон Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн сонгосон 9 зорилтын дугаарыг байрлуулж, харилцан нөлөөллийг оноогоор дүгнэсэн. МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилтын текстийг Хүснэгт 4-д өмнө харуулсан тул энд давтан харуулаагүй. Өөрөөр хэлбэл, МУТХҮБ-2030-ын ХАА, Аялал жуулчлал, Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн сонгосон 9 зорилт ТЭХтББ-ын зорилтуудад ямар нөлөө үзүүлэхийг оноогоор үнэлэв.

Загвар матриц 6. МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилт ТЭХТББ-д хэрхэн нөлөөлөх байдлын үнэлгээ

МУТХҮБ-2030-ын зорилтууд		Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого						Дүн	Онооны үнэлгээ (хувь)
		Тэргүүлэх чиглэл 1			Тэргүүлэх чиглэл 2		Тэргүүлэх чиглэл 3		
		1.1.	1.2.	1.3.	2.1.	2.2.	3.1.		
Хөдөө аж ахуй	Зорилт 1	0	0	0	0	0	0	0	0
	Зорилт 2	0	0	0	0	0	0	0	0
	Зорилт 3	0	0	0	0	0	0	0	0
	Зорилт 4	-2	0	0	0	0	0	-2	-11
Аялал жуулчлал		0	1	0	0	1	1	3	17
Аж үйлдвэр	Зорилт 1	-1	0	0	0	3	2	4	22
	Зорилт 2	-1	0	0	0	0	0	-1	-5
	Зорилт 3	-1	0	0	0	0	0	-1	-5
	Зорилт 4	-1	0	0	0	0	0	-1	-5
Дүн		-6	1	0	0	4	3	2	1

Энэхүү матрицыг бид дээр авч үзсэн Загвар матриц 3-д хийсэн бүх тайлбартай нэгэн адилаар дүгнэж, үнэлгээг өгнө. Ерөнхийдөө МУТХҮБ-2030-ын ХАА, Аялал жуулчлал, Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн сонгосон 9 зорилтыг хэрэгжүүлснээр ТЭХТББ-ын хэрэгжилтэд төдийлөн хүчтэй нөлөө үзүүлэхгүй нь онооны үнэлгээнээс харагдаж байна. Үүгээр зогсохгүй Аж үйлдвэрийн салбарын зорилтуудыг хэрэгжүүлснээр эрчим хүчний нэмэлт эрэлт үүсэж, эрчим хүчний салбарын найдвартай хангамж, аюулгүй байдалд зарим сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэдгийг хасах тэмдэгтэй 5 оноонууд харуулж байна. Яг ийм байдлаар ДТХЗ-ууд болон ТЭХТББ-ын зорилтуудын нөлөөг үнэлж болно.

Одоо бид дээрх Загвар матриц 6-ын мөр, баганыг сольж, эсрэгээрээ ТЭХТББ-ын зорилгуудыг хэрэгжүүлсэн тохиолдолд МУТХҮБ-2030-ын ХАА, Аялал жуулчлал, Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн сонгосон 9 зорилтын хэрэгжилтэд ямар нөлөө үзүүлэхийг оноогоор дүгнэж, үнэлгээ өгье.

Загвар матриц 7. ТЭХТББ МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилтод хэрхэн нөлөөлөх байдлын үнэлгээ

МУТХҮБ-2030 Эрчим хүчний бодлого	Эдийн засгийн тогтвортой хөгжил									Онооны үнэлгээ (хувь)	
	Хөдөө аж ахуй				Аялал жуулчлал	Аж үйлдвэр					Дүн
	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4		Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4		
Тэргүүлэх чиглэл 1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах											
1.1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах (6)	2	3	1	3	3	1	2	3	3	21	78

1.2. Бүс нутгийн орнуудтай эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх (4)	1	1	1	1	1	1	1	1	2	2	11	41
1.3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах (3)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тэргүүлэх чиглэл 2. Эрчим хүчний үр ашиг бүтээмжийг дээшлүүлэх												
2.1. Эрчим хүчний салбарыг хувийн хэвшилд суурилсан, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх (3)	0	0	0	0	0	0	0	0	1	1	2	7
2.2. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх (5)	0	0	0	0	0	1	0	1	1	1	3	11
Тэргүүлэх чиглэл 3. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих												
3.1. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах (6)	3	3	3	3	3	1	2	1	1	1	20	74
Дүн	6	7	5	7	7	4	5	8	8	8	57	35

ТЭХТББ-ыг хэрэгжүүлснээр МУТХҮБ-2030-ын ХАА, Аялал жуулчлал болон Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн сонгосон 9 зорилтыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр гарч байна. Ялангуяа эрчим хүчний бодлогын Зорилго 1.1 болон 3.1-ийн үзүүлэх нөлөөний онооны үнэлгээ сүүлийн баганад 74-78 хувь байгаа нь эрчим хүчний энэхүү 2 зорилгын хэрэгжилт МУТХҮБ-2030-ын сонгосон 9 зорилтыг хэрэгжүүлэхэд хүчтэй эерэг нөлөөтэй болохыг харуулж байна. Учир нь эрчим хүч хэрэглэдэггүй салбар үгүй бөгөөд энэхүү суурь салбар нь бусад салбаруудын тогтвортой хөгжилд маш их нөлөөтэй гэдэг нь харагдаж байна.

Бид энэ жишээн дээр ТЭХТББ-ыг 6 зорилгоор төлөөлүүлэн авсан бол МУТХҮБ-2030-ын ХАА, Аж үйлдвэр, Аялал жуулчлалын салбарын хөгжлийн 9 зорилтыг сонгон харуулсан. МУТХҮБ-2030-ын бүх зорилтуудыг дээрх байдлаар томоохон матриц үүсгэн үнэлгээ өгч, бүрэн хэмжээгээр дүгнэнэ.

Чиглэл 3: Салбарын дунд хугацааны бодлогын хэд хэдэн баримт бичигтэй тохиолдолд тэдгээр нь өөр хоорондоо хэрхэн уялдсан, өөр цаг хугацаанд батлагдсан салбарын бодлогын баримт бичгүүдийн залгамж чанар нь хадгалагдсан эсэхийг үнэлнэ. Энэ шатанд зарим аймгуудаар жишээ болгон салбарын бодлого орон нутгийн хөгжлийн бодлогод хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлгээ өгнө. Энэ чиглэлээр салбарын дунд хугацааны бодлогын хэд хэдэн баримт бичгүүдээр доорх хэлбэрийн матриц байгуулж, салбарын хөгжлийн тодорхой асуудлаарх зорилт, заалтуудыг харьцуулан бодлогын уялдааг шинжилнэ.

I үе шат: Салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа, бодлогын гол зорилтууд залгамж чанартайгаар тусгагдсан байдлыг үнэлэх арга зүй (Жишээ болгон хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн авав).

Загвар матриц 8. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	“Монгол мал” үндэсний хөтөлбөр	Үнэлгээ, 3 ангиллаар	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого	Үнэлгээ, 3 ангиллаар
Бодлогын гол зорилтууд	Холбогдох зорилт, заалт байвал бичнэ.		Холбогдох зорилт, заалт байвал бичнэ.	

Энэхүү матрицын нүднүүдэд тухайн асуудлаар баримт бичигт тусгагдсан зорилтуудыг текстээр бичнэ. Тэдгээрийн өөр хоорондоо уялдсан байдлыг нь харьцуулан 3 ангилсан үнэлгээг өгч, дүгнэлт гаргана. Энэхүү матрицыг бүрэн нөхсөнөөр Чиглэл 1-ийн 1-р шатанд хийсэнтэй адил дүгнэлтийг, тухайлбал, "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" (ТХХААтББ)-ын нийт зорилтуудын хэдэн хувь нь шууд тусгагдсан, хэдэн хувь нь агуулгын хувьд уялдсан, хэдэн хувь нь огт тусгагдаагүйг дүгнэх байдлаар үнэлгээг өгнө.

II үе шат: Салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн өөр хоорондын уялдаа, харилцан нөлөөллийг оноогоор үнэлэх арга зүй.

Бид жишээ болгон ТХХААтББ-ыг хэрэгжүүлснээр “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд ямар нөлөө үзүүлж болохыг үнэлэхээр эдгээр баримт бичгүүдээс цөөн тооны зорилтуудыг сонгон авч харьцуулан үнэлгээг хийе.

ТХХААтББ Зорилго 2.1.-ийн доорх зорилтуудыг сонгов.

- 2.1. МАА-н үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:
 - 2.1.1. МАА-н үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр эрчимтэй хөгжүүлж, махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх;
 - 2.1.2. МАА-н салбарын хөгжил дэх төрийн зохицуулалт, дэмжлэгийн чиглэл, МАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн үүрэг, хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох;
 - 2.1.3. Малын генетик нөөцийн бүртгэл, төлөв байдлын үнэлгээ, ашиглалт, хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох, МАА эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах;
 - 2.1.4. Малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримтлах, МАА-н үйлдвэрлэлийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх;
 - 2.1.5. Мал, амьтны үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулж, бүс нутгийн онцлогт тохирсон шинэ үүлдэр, омгийг бий болгон, генийн санг хамгаалах болон малын нөхөн үржүүлгийг сайжруулахад био технологийн ололтыг ашиглах, малын

үржүүлэг, технологийн орон нутгийн нэгжүүдийг чадавхжуулах;

- 2.1.6. Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, эрүүлжүүлэх стратегийг бүсчлэн хэрэгжүүлэх, халдварт өвчний тохиолдлыг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах, халдварт өвчингүй тайван байдлыг тодорхой бүс нутгаар баталгаажуулах;
- 2.1.7. Олон улсын жишиг, шаардлагад нийцсэн мал эмнэлгийн албаны үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангасан тогтолцоог сумын түвшин хүртэлх бүх шатанд бүрдүүлэх, орон нутгийн мал эмнэлгийг чадавхжуулж, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлэх;
- 2.1.8. Мал эмнэлгийн үйлчилгээнд зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх;
- 2.1.9. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлснээс бусад бэлчээрийг төрийн эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалттайгаар ашиглуулах, эрчимжсэн МАА-д тэжээл тариалах зориулалтаар тариалангийн газрыг ашиглуулах;
- 2.1.10. Бэлчээр болон байгалийн бусад нөөцийн зохистой ашиглалт, бэлчээрийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, удирдлагын тогтолцоог сайжруулах, отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх;

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн доорх зорилтуудыг сонгов.

- 3.1. Нэгдүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: МАА-н салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.
 - 3.1.1. МАА-н салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох:
 - 3.1.1.1. Бэлчээр ашиглах, хамгаалах, эзэмших, бэлчээрийн болон эрчимжсэн МАА эрхлэх бүс нутгийн хил заагийг тодорхой болгох талаарх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
 - 3.1.1.2. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулж, малын бүртгэлжүүлэлт, мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний нэгжийн чадавхыг сайжруулах эрх зүйн орчныг бий болгох;
 - 3.1.1.3. МАА-н хөгжлийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулан, МАА-н үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, малчдын хөдөлмөрийн үнэлгээг сайжруулах, урамшуулах тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх;
 - 3.1.1.4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Газрын төлбөрийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Улсын нөөцийн тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 3.1.1.5. “Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг сайжруулах стратеги, төлөвлөгөө”, “Малын үржлийн ажил, үйлчилгээний стратеги төлөвлөгөө”, “Тэмээ”, “Бэлчээр, тэжээл”, “Мах”, “Сүү”, “Ноос”, “Ноолуур”, “Арьс шир” дэд хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх.
 - 3.1.2. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх, анхан шатны нэгжийг бэхжүүлэх:

3.1.2.1. Сумдад мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний албыг бий болгож, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.2.2. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний анхан шатны нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтний хүрэлцээ хангамж, чадавхыг сайжруулахад төрөөс дэмжих;

3.1.2.3. Малын удмын сан, эрүүл мэндийн холбогдолтой мэдээ, мэдээллийг олон улсын шаардлагад нийцүүлэх, мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийг хамарсан сүлжээ байгуулж, мэдээллийг шуурхай дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх.

Доорх Загвар матриц 9-ийн мөр, баганад ХАА-н бодлогын 2 баримт бичгийн сонгосон зорилтуудын дугаарыг байрлуулав.

Загвар матриц 9. ТХХААТББ-ын “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

		“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн сонгосон зорилтууд							Дүн	Онооны үнэлгээ (хувь)	
		3.1.1.1.	3.1.1.2.	3.1.1.3.	3.1.1.4.	3.1.1.5.	3.2.1.1.	3.2.1.2.			3.2.1.3.
“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарын баримтлах бодлого”-ын сонгосон зорилтууд	2.1.1.	0	0	0	0	2	0	0	0	2	8
	2.1.2.	1	1	1	1	1	2	2	2	11	46
	2.1.3.	0	0	0	0	0	0	0	1	1	4
	2.1.4.	0	0	0	0	0	0	0	1	1	4
	2.1.5.	0	0	0	0	2	2	2	3	9	37
	2.1.6.	0	0	0	0	0	1	2	2	5	21
	2.1.7.	0	0	0	0	2	2	2	2	8	33
	2.1.8.	0	0	0	0	2	2	2	2	8	33
	2.1.9.	0	0	0	0	1	0	0	0	1	4
	2.1.10.	0	0	0	0	1	0	0	0	1	4
Дүн		1	1	1	1	12	9	10	12	47	20

Энэхүү матрицыг бид дээр авч үзсэн Загвар матриц 3-д хийсэн бүх тайлбартай нэгэн адилаар дүгнэж, үнэлгээг өгнө. Матрицаас харахад нөлөөллийн үнэлгээний хувь төдийлөн өндөр биш гарч байна. Харин ТХХААТББ-ын 2.1.2 болон 2.1.1.5. дугаартай зорилтууд “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд бага боловч нөлөөтэй гарсан байна.

Чиглэл 4: Үндэсний болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр", уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, яам, агентлагуудын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги, төлөвлөгөөнүүдэд хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлгээ хийнэ.

I үе шат: МУТХҮБ-2030 болон салбарын хөгжлийн бодлогын зорилтууд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр" болон салбарын дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсаныг шалгаж, үнэлгээ өгөх арга зүй.

МУТХҮБ-2030 болон салбарын хөгжлийн бодлогын зорилтууд "Засгийн газрын 2016-

2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр" болон салбарын дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсаныг шалгаж, үнэлгээ өгөхдөө доорх матрицыг ашиглана.

Загвар матриц 10. МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогын зорилтууд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан 3-огт тусгагдаагүй
МУТХҮБ-2030-ын 44 зорилтоос гадна зарчим гэсэн хэсэгт орсон хэсгүүдээс холбогдох байдлаар нь зэрэгцүүлэн харуулна.	Холбогдох зорилт, заалт байвал бичнэ.	Дээрх ангиллын аль тохирохоор нь үнэлнэ.

Энэ матрицаас МУТХҮБ-2030-д тусгагдсан зорилтууд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан эсэх нь харагдах болно.

Загвар матриц 11. ТЭХТББ-д тодорхойлсон зорилго, зорилтууд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан байдал

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй,
Зорилго, зорилтуудыг харуулна.	Холбогдох зорилт, заалт байвал бичнэ.	Дээрх ангиллын аль тохирохоор нь үнэлнэ.

Хэрэв ТЭХТББ-д заасан зорилтууд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т бүрэн тусгагдаагүй бол цаашид ямар арга хэмжээ авах тухай саналаа гаргана.

Хавсралт 2-д ТЭХТББ "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан байдлыг тусгайлан харуулав. Хавсралтаас харахад ТЭХТББ-ын 3 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 6 зорилго, нийт 27 зорилтыг дэвшүүлсний 6 зорилт нь "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тодорхой ажил, үйл ажиллагаа болж тусгагдсан, харин үлдсэн 21 зорилт буюу 78 хувь нь тусгагдаагүй байна. ТЭХТББ нь цаг хугацааны хувьд 2030 онд дуусах бөгөөд дээрх зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд дараа дараагийн Засгийн газруудад хийх ажил нэлээд үлдэж байна. Энэ жишээ нь дунд хугацааны төлөвлөгөө байхгүй өнөөгийн нөхцөлд урт хугацааны бодлогын зорилтуудыг үе шаттайгаар хуваарилаагүй тул тэдгээр нь ийнхүү Засгийн газруудын мөрийн хөтөлбөрүүдэд бүрэн тусгагдахгүй үлдэх магадлал өндөр байгааг харуулж байна.

II үе шат: Салбарын хөгжлийн бодлогын зорилтууд болон "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн харилцан нөлөөллийг үнэлэх арга зүй.

Энд бид ТЭХТББ "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т үзүүлэх нөлөөллийг сонгон авч үзлээ. Бодлогын нөлөөллийг дээр дурдсан энгийн харилцан нөлөөллийн матрицын аргаар 7 түвшний оноогоор үнэлж гаргана. "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр" нь тодорхой бодлогын хүрээнд явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Ийм учраас хөтөлбөр нь маш дэлгэрэнгүй үйл ажиллагааг хамрах тул зарим салбарыг төлөөлүүлэн тодорхой сонгосон үйл ажиллагаануудыг энд жишээ болгон авч үзлээ. Матрицын багануудад дугаарласан

хөтөлбөрийн үйл ажиллагаануудыг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллаганы хөтөлбөр"-т тусгагдсан зарим сонгосон үйл ажиллагаанууд

2.1.	Монгол Улсын үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
2.2.	Монгол Улсад үйлдвэрлэсэн уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүний 50-иас дээш хувийг экспортод гаргаж байгаа аж ахуйн нэгжийг татварын бодлогоор дэмжинэ.
2.18.	Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.
2.19.	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлнэ.
2.25.	МАН-н үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх ба түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
2.26.	“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2.39.	Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон, үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.
2.40.	Жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.

Эх сурвалж: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Доорх Загвар матриц 12-т "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан зарим сонгосон үйл ажиллагаанууд ТЭХтББ-ын хэрэгжилтэд ямар нөлөө үзүүлэхийг оноогоор үнэлж харуулав.

Загвар матриц 12. "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн ТЭХтББ-ын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөлөл

		Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого						Дүн	Онооны үнэлгээ (хувь)
		Тэргүүлэх чиглэл 1			Тэргүүлэх чиглэл 2		Тэргүүлэх чиглэл 3		
		1.1.	1.2.	1.3.	2.1.	2.2.	3.1.		
Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн сонгосон үйл ажиллагаанууд	2.1.	-2	0	0	0	0	0	-2	-11
	2.2.	0	0	0	0	0	0	0	0
	2.18.	0	0	0	0	0	0	0	0
	2.19.	0	0	0	0	0	0	0	0
	2.25.	0	0	0	0	0	0	0	0
	2.26.	0	0	0	0	0	0	0	0
	2.39.	0	0	0	0	0	0	0	0
	2.40.	0	0	0	0	0	0	0	0
Дүн		-2	0	0	0	0	0	-2	1

Дээрх матрицаас харахад "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан бидний сонгосон үйл ажиллагаанууд ТЭХТББ-ын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх үнэлгээ гарсан байна. Хэрэв "Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөр"-ийн бүх үйл ажиллагааг бүрнээр нь тусгавал үр дүн нь сөрөг гарахгүй байж болно. Энэ нь бидний сонголттой холбоотой. Энд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан 2.1. дугаартай үйл ажиллагаа болох "Монгол Улсын үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлсэн нөхцөлд ТЭХТББ-ын Тэргүүлэх чиглэл 1-ийн Зорилго 1.1-д тусгасан "эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах" зорилтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлнө гэж -2 оноо өгсөнтэй холбоотой байна. Энэхүү оноог хүнд үйлдвэрийг хөгжүүлэх нь эрчим хүчний шинэ эрэлт хэрэгцээг бий болгож, эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдалд хүндрэл учруулна гэж үзсэний үндсэн дээр өгсөн болно. Энэ матрицад "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан бусад сонгосон үйл ажиллагаанууд ТЭХТББ-ын зорилтуудад ямар нэг нөлөөгүй, бүгд 0 оноотой байгаа нь үүнд бас нөлөөлжээ.

Доорх матрицад эсрэгээр нь ТЭХТББ-ын "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан зарим сонгосон үйл ажиллагаануудад ямар нөлөө үзүүлэхийг оноогоор үнэлж үзэв.

Загвар матриц 13. ТЭХТББ-ын "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөөлөл

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Эрчим хүчний бодлого	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн сонгосон үйл ажиллагаанууд									Дүн	Онооны үнэлгээ (хувь)
	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого										
	2.1.	2.2.	2.18.	2.19.	2.25.	2.26.	2.39.	2.40.			
Тэргүүлэх чиглэл 1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах											
1.1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах (6)	1.1.	3	0	1	1	1	0	1	1	8	33
1.2. Бүс нутгийн орнуудтай эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх (4)	1.2.	0	0	0	0	0	0	0	0	0	0
1.3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах (3)	1.3.	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тэргүүлэх чиглэл 2. Эрчим хүчний үр ашиг бүтээмжийг дээшлүүлэх											
2.1. Эрчим хүчний салбарыг хувийн хэвшилд суурилсан, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх (3)	2.1.	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх (5)	2.2.	0	0	0	0	0	0	0	0	0	0

Тэргүүлэх чиглэл 3. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих											
3.1. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах (6)	3.1.	0	0	3	3	3	3	1	1	14	58
Дүн		3	0	4	4	4	3	2	2	22	15

Энэхүү матрицаас харахад бидний өгсөн 7 түвшний үнэлгээгээр ТЭХтББ-ыг хэрэгжүүлэх нь "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан Хүснэгт 4-д харуулсан сонгосон үйл ажиллагаануудын хэрэгжилтэд багагүй нөлөөтэй болохыг харуулж байна. Ялангуяа, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого нь "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан Хүнсний аж үйлдвэрийг хөгжүүлэх, "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэхэд нөлөөтэй гарсан нь мөрийн дүн 14 оноотой, онооны үнэлгээний хувь 58 гарснаас харагдаж байна.

БҮЛЭГ 3. ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ДАРААЛАЛ, ХҮРЭХ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙ

3.1. Хөгжлийн тэргүүлэх чиглэл, дарааллыг тодорхойлох арга зүй

Дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох арга зүйн ерөнхий зарчим бол дээрээс доош нь төлөвлөх (Top-down approach) болон доороос дээш нь төлөвлөх (Bottom-up approach) арга байна.

Дээрээс доош төлөвлөх арга гэдэг нь дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо урт хугацааны бодлогод тусгагдсан алсын харааг сайтар харгалзан үзэж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлно гэсэн үг юм.

- Бид одоо хаана байна вэ?
- Дунд хугацаанд бид хаана очих вэ?
- Тавьсан зорилтдоо ямар арга замаар хүрэх вэ? хэмээх асуултуудад хариулна гэсэн үг юм.

Урт хугацааны тогтвортой хөгжлийн гол шаардлагуудыг олон улсын түвшинд доорх байдлаар тодорхойлж байна.

Эдийн засгийн хүрээнд:

- Нөөцийн үр ашигтай байдлыг хангах;
- Ажил эрхлэлтийн түвшин өндөр, бизнесийн идэвх нэмэгдсэн байх;
- Бүтээмжтэй байх;
- Татварын дарамтгүй байх.

Нийгмийн хүрээнд:

- Тэгш байдалд хүрэх;
- Хүмүүсийн эрүүл мэнд сайжирсан байх;
- Боловсрол дээшилсэн байх;
- Амьдралын чанар сайжрах;
- Орон нутаг хөгжих;
- Бүх нийтийн оролцоо хангагдсан байх.

Байгаль орчны хүрээнд:

- Бохирдлоос хамгаалагдсан байх;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн байх;
- Биологийн төрөл зүйл хамгаалагдсан байх.

Эдгээр шаардлагыг улс орнууд болон олон улсын байгууллагууд тогтвортой хөгжлийн хөтөлбөр, үзэл баримтлалдаа харгалзан тусгадаг. МУТХҮБ-2030-д тогтвортой хөгжлийн эдгээр нийтлэг шаардлага үндсэндээ тусгагдсан.

Дээрээс төлөвлөх зарчим нь урт хугацааны бодлогод тодорхойлсон алсын хараанаас эхэлнэ. Алсын хараа нь “Алтан гадас чигийг заана” гэх утгатай адил улс орны хөгжлийн алс хэтийн нэгтгэсэн ерөнхий ганц зорилго болж өгөх ёстой. МУТХҮБ-2030-д манай орны хөгжлийн алсын харааг Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно хэмээн тодорхойлсон.

Иймээс дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд нь энэхүү алсын харааг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөгжлийн тэргүүн зэрэгт анхаарах зорилтууд байх ёстой. Энд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн үе шат бүр нь дараагийнхаа үе шаттай уялдсан, түүнд чиглэсэн логик уялдаатай байх шаардлагатай. Тухайлбал, 2020-2025 оны дунд хугацааны хөгжлийн зорилтууд нь дараагийн дунд хугацааны зорилтуудтайгаа уялдсан бөгөөд 2030 оны хүрэх түвшинг хангасан логик дэс дараалал, нягт холбоотой байна.

Зураг 3. Дээрээс доош төлөвлөх төсөөлөл




Дээрээс доош төлөвлөх зарчим нь алсын хараатайгаа уялдсан, түүнд үе шаттайгаар хүрэх бодлогын зорилтуудыг дунд хугацаанд оновчтой тодорхойлоход чиглэгдэнэ гэсэн үг юм.

Алсын харааг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөгжлийн бодлого нь 2 түвшинд тодорхойлогдоно. Үүнд:

- Макро түвшний бодлогууд
- Салбарын хөгжлийн бодлогууд


Энэхүү 2 түвшний бодлого нь хоорондоо нягт уялдаатай, салбарын бодлогууд нь макро түвшний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой. Макро болон салбарын бодлогуудыг олон улсын нийтлэг зарчмаар зорилго, зорилго нь дотроо зорилтууд болон задарсан доорх хэлбэрийн дараалалтайгаар тодорхойлно.

Зураг 4. Хөгжлийн бодлогын зорилго, зорилтуудын эрэмбэ



Салбарын хөгжлийн бодлого нь мөн дээрхийн адил эрэмблэгдсэн зорилго, зорилтуудаас бүрдэх бөгөөд макро түвшний бодлоготойгоо нягт холбоотой байна.

Зураг 5. Салбарын хөгжлийн бодлогын зорилго, зорилтууд



Макро түвшний урт хугацааны нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бодлогууд одоо ч зарим нь тодорхой байгаа юм. Үүнд урт хугацаанд Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, түүнийг илүү олон салбартай болгох, улс орныг үйлдвэржүүлэх бодлого гэх мэт хамаарна. Салбаруудын хувьд аль болох нэмэгдсэн өртөг өндөртэй, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортод гаргах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг эрс нэмэгдүүлэх гэх зэрэг бодлогууд байж болно. Эдгээрийг бид дунд хугацааны тэргүүлэх чиглэлдээ зорилтууд болгон тусгах боломжтой. Гэхдээ урт хугацаанд хэрэгжих боломжтой бодлогыг дунд хугацаандаа хэрэгжих хэмжээгээр нь оновчтой тодорхойлох шаардлага гарна.

Доороос дээш төлөвлөх зарчмаар дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлохдоо 2 чиглэлээр гүйцэтгэнэ. Эхний чиглэл нь салбар бүрийн хөгжлийн бодлогод тодорхойлсон дунд хугацааны бодлогын зорилтуудыг харгалзан үзнэ. Жишээлбэл, Төрөөс эрчим хүчний салбарт баримтлах бодлогод доорх 3 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

Тэргүүлэх чиглэл 1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах.

Тэргүүлэх чиглэл 2. Эрчим хүчний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх.

Тэргүүлэх чиглэл 3. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих.

Эдгээр тэргүүлэх чиглэлээс аль нь илүү нөлөөтэй болохыг бид өмнөх бүлэгт Загвар матриц 5-д харуулсан. Энэхүү матрицын баруун гар талын дүнд Тэргүүлэх чиглэл 1-ийн эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах Зорилт 1.1.-ийн дүнгээр 12 оноо гарсан бол бүс нутгийн орнуудтай эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилт 1.2.-ын дүнгээр 5 оноо болж, нийтдээ Тэргүүлэх чиглэл 1-ийн дүн 17 оноо болсон. Бодлогын энэхүү тэргүүлэх чиглэл нь МУТХҮБ-2030-ын ХАА болон Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх 5 зорилтыг хэрэгжүүлэхэд эерэг хүчтэй нөлөө үзүүлэхээр гарсан тул дунд хугацааны хөгжлийн бодлогод энэхүү тэргүүлэх чиглэлийн хүрээнд бодлогын зорилтуудаа хадгалан авч хэрэгжүүлэхээр сонгоно гэсэн үг юм. Гэхдээ энд бид жишээгээ МУТХҮБ-2030-ын ХАА болон Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх 5 зорилтоор хязгаарласан билээ. Бид Загвар матриц 5-ыг бүрэн хэмжээгээр байгуулж, ТЭХТББ-д тусгагдсан зорилт бүр МУТХҮБ-2030-ын зорилт бүрт эхний түвшинд шууд байдлаар хэрхэн нөлөөлөхийг тооцож, гаргасан оноог харгалзан дунд хугацааны бодлогоо тодорхойлно.


Мөн Загвар матриц 5-ын Тэргүүлэх чиглэл 3-ын дүнгээр 15 оноо гарсныг харж болно. Энэ нь МУТХҮБ-2030-ын ХАА болон Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх 5 зорилтыг хэрэгжүүлэхэд ихээхэн нөлөөтэй болохыг харуулж байна.

Доороос төлөвлөх аргын дараагийн зайлшгүй хийгдэх үе шат нь оролцооны аргаар салбарын өмнө тулгамдсан шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийн МУТХҮБ-2030-ын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийг дээрх матрицын аргаар тооцож, тэргүүлэх чиглэлээ тодорхойлох явдал юм. Салбарын өмнө тулгамдсан асуудлыг тодорхойлох хамгийн түгээмэл арга зүй бол “Асуудлын мод” (Problem Tree) гэж нэрлэгддэг арга юм.

Шигтгээ 2: “Асуудлын мод” хэмээх арга зүй

Асуудлын мод нь тодорхой асуудлын шалтгаан, үр дагавруудыг бүхэлд нь харах боломж олгодог. Энэ нь тухайн асуудлын онцлог шинжийг гаргаж ирдэг тул хөгжлийн төлөвлөлтийн үйл явцад чухал юм. Асуудлын модны шинжилгээг хийхдээ өнөөгийн тулгарч буй асуудлын шалтгааныг тодорхойлсноор асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг олдог. Асуудлын мод нь гол асуудлыг бий болгож буй хэд хэдэн суурь шалтгаан, модны мөчир буюу үр дагаврын харилцан хамаарлыг гаргаж ирснээр нийгмийн өмнө тулгамдаж буй асуудлыг зөв тодорхойлох боломжийг бүрдүүлдэг. Мөн одоогоор хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд шийдвэрлэгдээгүй хүчин зүйлсийг ч гэсэн энэхүү модны тусламжтайгаар тодорхойлж болно.

Зураг 6. Асуудлын мод



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны баг.

Эндээс гарсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх бодлогын зорилтууд болгон хувиргаж, томъёолно. Энэхүү зорилтууд нь дунд хугацааны хөгжлийн бодлогын салшгүй нэг хэсэг болох ёстой. Оролцооны аргаар салбарын өмнө тулгамдсан шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлохдоо дараах хүчин зүйлийг харгалзана. Нэгдүгээрт, суурь болох салбарын бодлого нэгдүгээрт байх ёстой. Харин дараагийн түвшинд дэс дарааг хэр “чухал бөгөөд хэр яаралтай” гэсэн үзүүлэлтүүдийг авч тодорхойлох боломжтой. Доорх загвар хүснэгтийг харна уу.

Загвар матриц 14. Ач холбогдлоор нь дараалал тодорхойлох загвар

	Яаралтай	Яаралтай биш
Чухал	Яг одоо хийх	Хэзээ яаж хийх, стратеги, цаг хугацаагаа гарга
Чухал биш	Бусдад даатга: хийж чадах хүнээ олох	Огт хэрэггүй устга

	Богино хугацаа	Урт хугацаа
Ач холбогдол бага	Шаардлагагүй	Шаардлагагүй
Ач холбогдол өндөр	Шууд хэрэгжүүл	Хэзээ яаж хэрэгжүүлэхээ тодорхойл

Дэс дарааг дараагийн байдлаар гаргаж болно. Үүнд: “Шууд хэрэгжүүл” бодлого нь эхний ээлжинд, харин дараа нь “Хэзээ, яаж хэрэгжүүлэхээ тодорхойл” бодлого байна.

Загвар матриц 15. Хэрэгжилтийн дараалал тодорхойлох загвар

	Өндөр үр нөлөө	Бага үр нөлөө
Өндөр өртөг	Хэзээ яаж хэрэгжүүлэхээ тодорхойл	Огт хэрэггүй
Бага өртөг	Шууд хэрэгжүүл	Шаардлагагүй

Оролцооны аргаар салбарын өмнө тулгамдсан шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлж, түүнээс дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгах тэргүүлэх зорилтуудыг тодорхойлохдоо бидний дээр авч үзсэн харилцан хамаарлын энгийн матрицын аргыг

ашиглана.

Бид энд газар тариалангийн салбарын тулгамдсан асуудлуудыг жишээ болгон авч үзье.

Загвар матриц 16. Газар тариалангийн тулгамдсан асуудлуудын харилцан нөлөөлөл, уялдаа

	Үрийн чанар, бэлтгэх тогтолцоог сайжруулах	Техникийн шинэчлэлт хийх	Зоорь, агуулахын аж ахуйг хөгжүүлэх	Хөрсний доройтлыг сэргээж хамгаалах доройтлыг сэргээх, хамгаалах	Усалгаатай тариалан, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх	Дүн
Үрийн чанар, бэлтгэх тогтолцоог сайжруулах		0	0	0	3	3
Техникийн шинэчлэлт хийх	0		0	2	3	5
Зоорь, агуулахын аж ахуйг хөгжүүлэх	3	0		0	3	6
Хөрсний доройтлыг сэргээх, хамгаалах	3	0	0		2	5
Усалгаатай тариалан, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх	3	0	1	2		6
Дүн	9	0	1	4	11	25

Энэхүү матрицаас харахад газар тариалангийн салбарын өмнө тулгамдсан шийдвэрлэх асуудлууд өөр хоорондоо ихээхэн хамааралтай, бие биендээ нөлөөтэй байна. Үүнээс зоорь, агуулахын аж ахуйг хөгжүүлэх, усалгаатай газар тариалан болон хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зорилтууд бусад зорилтуудын хэрэгжилтэд нэлээд эерэг нөлөөтэй, тус бүрдээ 6 оноотой гарсан тул энэ салбарын бодлогын зорилтууд дотроос тэргүүлэх чиглэлд сонгон оруулах боломжтой, ач холбогдол өндөртэй зорилтууд гэдэг нь харагдаж байна.

Ийм байдлаар бид дунд хугацааны бодлогын тэргүүлэх зорилтуудын эхний хувилбаруудыг гаргаж, алсын харааг хэрэгжүүлэхэд тэдгээрийн үзүүлэх нөлөөг харгалзан сонгоно.

3.2. Үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг тодорхойлох арга зүй

Дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд тодорхой болсны дараа зорилго, зорилт бүрийг аль болох хэмжээст оруулж, үзүүлэлтээр илэрхийлэх, бөгөөд албан ёсны статистикаас болон яам, агентлагуудаас гаргадаг үзүүлэлт байгаа эсэхийг

тогтооно.

Хэмжих үзүүлэлтүүд тодорхойлогдсоны дараа зорилго, зорилтуудын хүрэх түвшинг нөхцөл байдлын шинжилгээг үндэслэн тогтооно. Хүрэх түвшинг бодит тооцоон дээр үндэслэн гаргах хэрэгтэй. Үүнд одоогийн суурь түвшин хэрэгтэй болно. Цаашид хандлага ямар байх, нөөцийн хүртээмж, хангамж, бусад таатай нөхцөл, эрсдэлүүдийг тооцох хэрэгтэй болно.

Юуны өмнө суурь оны түвшин болон ер нь сүүлийн 10 жилд уг үзүүлэлтийн өөрчлөгдөж ирсэн чиг хандлага, жилийн дундаж өсөлтийн хэмжээг тогтоож, боломжтой тохиолдолд түүний цаашдын өөрчлөлтийн чиг хандлагад прогноз, тооцоонуудыг он тус бүрээр хийнэ. Үзүүлэлт бүрийн хувьд дунд хугацаанд эерэгээр болон сөргөөр эрс нөлөөлөх хүчин зүйл гарах эсэхийг төсөөлнө. Энд сценари төлөвлөлтийн аргыг ашиглаж, хэд хэдэн боломжит хувилбар гаргаж болно.

Хүрэх түвшний зарим тооцоог Ерөнхий Тэнцвэрийн загвар (ЕТЗ) болон Нийгмийн Тооцооллын загвар ашиглан тооцон гаргаж, дээрх тооцоонуудтай тулган шалгаж, сонголт хийнэ. Хүрэх түвшинг тодорхойлох ажлын нэг гол хэсэг нь шаардлагатай хөрөнгө оруулалтыг тооцох ажил байна. Үүнийг загварын тооцоо болон гол салбаруудын тооцооноос гаргана.

3.2.1. МУТХҮБ-2030-ын үндсэн үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг тооцох арга зүй

МУТХҮБ-2030 нь Улсын Их Хурал (УИХ)-аар батлагдсан, бидний мөрдөж ажиллах ёстой Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг юм. Энэхүү баримт бичигт тусгагдсан хөгжлийн бодлогын зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх үндсэн үзүүлэлтүүдийн 2030 онд хүрэх түвшинг тогтоосон билээ.

Харин МУТХҮБ-2030-д тусгагдсан зорилтууд, тэдгээрийн үзүүлэлтүүдийн 2030 онд хүрэх түвшинг хэр үндэслэлтэй тогтоосон, хэрэгжих боломжтой эсэх нь өөр асуудал юм. Энэ нь дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад аяндаа тодорхой болох бөгөөд яваандаа МУТХҮБ-2030-д тодотгол, өөрчлөлтийг оруулах асуудлыг эрх бүхий байгууллагууд шийдвэрлэх болно. Ер нь улс орнуудын төлөвлөлтийн практикаас харахад урт хугацааны стратеги, төлөвлөлтдөө засвар өөрчлөлтийг шаардлагатай бол оруулдаг. Гэхдээ засвар, өөрчлөлтийг дан ганц тавьсан зорилтоосоо ухарсан, хүрэх түвшинг бууруулсан өөрчлөлт гэж үзэж болохгүй бөгөөд гол нь бодит байдалд хэрэгжих үндэстэй байх шалгуурыг хангасан байх л чухал юм. ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын үндсэн үзүүлэлтүүдийн 2030 онд хүрэх түвшинг урьдчилан тогтоосон байгаа тул одоо тэдгээрийг 2020 он, 2025 онд ямар түвшинд хүргэх, үүний дотор 2018-2025 оны жил бүрээр хүрэх түвшинг тооцох хэрэгцээ шаардлага гарч байгаа юм. Энэ нь МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд тусгах завсрын онуудын түвшинг тогтоох, үндсэндээ дээрээс доош болон доороос дээш төлөвлөх буюу эцсийн хүрэх түвшингээсээ ухрааж, завсрын онуудын хүрэх түвшинг тодорхойлж, нөгөө талаасаа бодит нөхцөл байдлаас үндэслэн доороос нь тооцох аргуудын хослол юм. Үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг тооцох арга зүй нь үзүүлэлт бүрийн хувьд өөрийн онцлогтой, өөр өөрөөр тооцох боломжтой. Гэхдээ нийтлэг тооцох арга зүй нь доорх 3 үндсэн үе шаттай хийгдэнэ. Үүнд:

I үе шат: Жилийн дундаж өсөлтийн хувийг ашиглан жил бүр жигд өсөлттэй нөхцөлд хүрэх түвшинг төсөөлөх

Энэ аргаар тооцохын тулд эхлээд одоогийн суурь түвшнээс 2030 он хүртэлх

завсрын онуудын жилийн дундаж өсөлтийн хувийг тусгай хүснэгт болон тооны машин ашиглан тооцно. Жишээ нь МУТХҮБ-2030-д 2030 он гэхэд нэг хүнд ногдох ҮНО-ыг 17500 ам.долларт хүргэх зорилт тавьсан. МУТХҮБ-2030-ын зорилтуудын суурь он болох 2014 онд Дэлхийн банкны эмхэтгэлд тодорхойлсноор Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО 4280 ам.доллар байсан.

Энэхүү хоёр оны өгөгдлийг ашиглан жилийн дундаж өсөлтийн хувийг тооцно. 2014-2030 оны хооронд нийтдээ 16 жилийн хугацаа байгаа бөгөөд энэ хугацаанд нэг хүн амд ногдох ҮНО-ыг 4,1 дахин өсгөх зорилтыг (17500/4280=4,089) МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн.

Жилийн дундаж өсөлтийг тооцдог тусгай хүснэгтийн 16 жил болон 4,1 дахин буюу 408,9 хувь өсөлтийн солбилцлыг олж харвал жилийн дундаж өсөлтийн хувь нь 9,2 байна. Ийм хүснэгт байхгүй тохиолдолд хялбархнаар компьютер доторх тооны машин ашиглан геометрын дунджийг дараах байдлаар бас тооцож болно. Энд Y-жилийн тоо, манай жишээгээр 16 жилийн дунджийг тооцох хэрэгтэй. X-16 жилийн өсөлтийн коэффициент. Бид компьютер доторх тооны машины дэлгэцэн дээр X болох 4,1-ийг оруулаад геометрийн дунджийн гэсэн товч дээр дараад араас нь Y болох 16 жилийг оруулахад доорх үр дүн гарна.

$$\sqrt[16]{x} = \sqrt[16]{4.1} = 1,092 \text{ буюу } 9,2 \text{ хувь болно.}$$

Үүний зөв эсэхийг хэлхээ индексийн үржвэр хэлбэрт оруулан шалгаж болно.

Жилийн дундаж өсөлтийн 9,2 хувийг 1,092 гэсэн индекс хэлбэрээр 16 удаа авч, үржвэрийг нь гаргахад 16 жилийн дараах 4,1 дахин өсөлт гарах ёстой. Өөрөөр хэлбэл, $4,1 = 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 * 1,092 = 4,088$ гарах болно. Эндээс 16 жилийн хугацаан дахь 4,1 дахин өсөлтийн жил бүрийн дундаж өсөлтийн хувь нь 9,2 болж байна. Одоо энэхүү жилийн дундаж өсөлтийн хувийг ашиглан Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын түвшин жил бүр жигд 9,2 хувиар өсөх нөхцөлд ямар түвшинд хүрч болохыг доорх хүснэгтэд харуулснаар тооцно.

Хүснэгт 6. Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын 2030 он хүртэлх өсөлтийн тооцоо, жилийн дундаж өсөлт тогтмол 9,2 хувь байх нөхцөлд
(ам.доллар)

	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Нэг хүн амд ногдох ҮНО, ам. доллар	4280	4673.7	5103.7	5573.3	6086	6645.9	7257.4	7925.1

2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
8654.2	9450.3	10319.8	11269.2	12306	13438.1	14674.4	16024.5	17498.7

Эх сурвалж : УХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Нэг хүн амд ногдох ҮНО-ын хэмжээг онуудаар тооцохдоо бид анхны 2014 оны түвшинг 1,092 гэсэн индексээр үржүүлж, 2015 оны түвшинг гаргаад цаашдаа урьдах оны түвшинг дээрх 1,092 индексээр үржүүлж дараагийн оны түвшинг тооцсон. Ингэснээр 2030 онд хүргэхээр төлөвлөсөн 17500 ам.долларт үндсэндээ хүрч байгааг харж байна.

Энэхүү арга нь өөрийн сул талтай. Сул тал нь ҮНО-ын хэмжээ жил бүр жигд тэнцүү өсөлттэй байхаар төсөөлж тооцдогт орших бөгөөд гэвч бодит амьдралд ийм байдаггүй. Гэхдээ энэхүү тооцоо нь бидэнд тодорхой баримжаа өгч байгаагаараа ач холбогдолтой завсрын тооцоо юм.

II үе шат: Үзүүлэлтийн өмнөх онуудын түвшний талаарх шаардлагатай нэмэлт судалгаа, тооцоог хийх

Хүрэх түвшинг тооцох явцад наад зах нь сүүлийн 10 жилийн уг үзүүлэлтийн өсөлт, өөрчлөлтийн талаарх нэмэлт судалгаа, тооцоог заавал хийнэ. Энэ нь бидний 2030 он хүртэлх төлөвлөсөн хэмжээ өнгөрсөн он жилүүдийн бодит өгөгдөлтэй хэр нийцэх, тавьсан зорилт сонгосон үзүүлэлтээр үнэхээр хүрэх боломжтой эсэхэд дүгнэлт өгөхөд чухал шаардлагатай байх болно.

Иймээс бид сүүлийн 10-аас дээш жилийн Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын хэмжээ, түүний өсөлт, өөрчлөлтийн динамик, чиг хандлагыг авч үзье. Сүүлийн 10 жилийн хугацаа нь уг үзэгдлийн өөрчлөлт, чиг хандлагыг шинжихэд хангалттай хугацаа гэж үзсэн болно. Зөвхөн сүүлийн 5 жилээр авч үзэх нь үндэслэл багатай бөгөөд учир нь эдийн засаг, бизнесийн мөчлөг, эдийн засгийн уналт, хямралт байдал, өсөлтийн мөчлөгийг илэрхийлэхэд уг хугацаа хангалттай биш юм.

Хүснэгт 7. Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО, Дэлхийн банкны атласын аргаар

(ам.доллар)

Он	Нэг хүн амд ногдох үндэсний нийт орлого	Жил бүрийн өсөлт, %
2000	390	100
2001	400	102.6
2002	430	107.5
2003	480	111.6
2004	600	125
2005	690	115
2006	1000	144.9
2007	1290	129
2008	1670	129.5
2009	1630	97.6
2010	1870	114.7
2011	2310	123.5
2012	3160	136.8
2013	3770	119.3
2014	4280	113.5
2015	3870	90.4

Эх сурвалж: ДБ, Дэлхийн хөгжлийн үзүүлэлт, 2002-2017.

Хүснэгтэд Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ыг сүүлийн 16 жилээр харуулсан

бөгөөд энэ үзүүлэлт хэдийгээр зарим жилүүдэд, тухайлбал, 2009 болон 2015 онуудад буурсан боловч ерөнхийдөө өндөр өсөлттэй өөрчлөгдөж ирсэн байна. Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын 2000-2015 оны жилийн дундаж өсөлт 16,5 хувь гарч байгаа нь бидний тооцоолсон 2030 он хүртэлх жилийн дундаж өсөлтийн 9,2 хувиас өндөр байна. Энэ нь өнгөрсөн он жилүүдийн динамик бодит өөрчлөлтөөр тооцоход бидний тооцоонд авсан 9,2 хувийн дундаж өсөлт биелэгдэх боломжтой байж болох талтайг харуулж байна.

III үе шат: Жигд өсөлтийн тооцоог бодит нөхцөлд аль болох тохируулан засварлах

Яг амьдрал дээр эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд бидний тооцсон шиг жил бүр тогтмол жигд өсдөггүй. Өөрөөр хэлбэл, бидний авч үзсэн жишээгээр Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын хэмжээ жил бүр тогтмол 9,2 хувиар өсөхгүй бөгөөд зарим жилд илүү өндөр өсч, зарим жилд тооцоноос багаар нэмэгдэж, эсвэл эсрэгээрээ бүр буурч ч болно. Тухайлбал, Дэлхийн банк Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын 2015 оны түвшинг 2014 оныхоос 410 ам.доллараар бууруулж, 3870 ам.доллар болгон зарласан. Хүснэгт 7-д бид уг үзүүлэлт жил бүр жигд өсөхөөр төсөөлсөн тул 2015 онд Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын хэмжээ өмнөх 2014 оноос 9,2 хувиар нэмэгдэж 4673,6 ам.долларт хүрэх ёстой байсан. Гэтэл 3870 ам.доллар болж буурсан. Эндээс дутсан хэмжээг дараа дараагийн онуудын тооцоонд шингээн тусгаж өгөх шаардлага гарна. Ингэхгүйгээр бид 2030 онд хүргэхээр тооцсон түвшиндээ хүрэхгүй болно. Тэгэхээр, энэ бүх бодит нөхцөлийг харгалзсан засвар, өөрчлөлтийг ялангуяа дунд хугацааны төлөвлөлтийн хүрээнд, тухайлбал, манай жишээгээр 2020-2025 оны хүрэх түвшинд тусгах шаардлагатай.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын хэмжээг атласын аргаар Дэлхийн банкаас хамааралгүй өөрсдөө бие даан тооцож ирсэн. Энэхүү тооцоо нь Дэлхийн банкныхтай яг таардаггүй боловч өсөлтийн ерөнхий чиг хандлагыг илэрхийлж чадна. Энэхүү тооцоог хийдэг аргачлалаар 2020-2025 оны хүрэх түвшинг ҮСХ-той хамтран тооцно.

Нэг хүн амд ногдох ҮНО хэмээх үзүүлэлтийг хүн амын дундаж тоо болон ҮНО-ыг ам.долларт шилжүүлсэн хэмжээ хоёроор тооцдог тул энэ хоёр үзүүлэлтийг тус бүрд нь 2020-2025 оноор тооцох шаардлагатай. Дунд хугацааны төлөвлөлтөд Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын хүрэх түвшинг аль болох бодитой төсөөлөхийн тулд эдийн засгийн өсөлт аль онд үнэхээр өндөр байхыг оновчтой тогтоох нь нэн чухал юм. Тэгэхээр, эхлээд ДНБ-ий өсөлтийг юуны түрүүнд 2020-2025 оноор бодитой таамаглах шаардлага гарна. Ялангуяа, үйлдвэрлэл, үйлчилгээний томоохон шинэ хүчин чадал, объектуудыг хэзээ ашиглалтад оруулж, ДНБ-ий хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхийг бодитой тооцох шаардлагатай. Тухайлбал, Оюу Толгойд цэвэр зэс боловсруулах үйлдвэр байгуулах үйлдвэрийг 2022 онд ашиглалтад оруулахаар Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хийгдэж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр яригдаж байна. Мөн Багануурын нүүрсний уурхайг түшиглэн байгалийн нийлэг хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулахаар төлөвлөж байна. Мөн Дорноговь аймгийн Алтанширээ суманд газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулахаар дэд бүтцийн ажлаа эхлээд байна. Энэ бүх объектуудын ТЭЗҮ-д тусгасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалтын хэмжээ ДНБ-ий өсөлтөд хэзээ ямар өөрчлөлт оруулахыг макро эдийн засгийн загвар тооцоонд тусгаж, ДНБ-ий хэмжээг дээрх онуудаар зөв төсөөлөх шаардлагатай. Ингэснээр, ДНБ-ээс ҮНО-ыг тооцож, түүнийг Дэлхийн банкны атласын аргаар ам.долларт шилжүүлэх тооцоог хийнэ. ҮСХ-ноос 2017 онд гаргасан хүн амын шинэчилсэн хэтийн тооцоогоор 2018-2022 оны хүн амын дундаж тоог доорх байдлаар тооцсон байгаа билээ.

Хүснэгт 8. Хүн амын тоо дундаж хувилбараар, Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амаар

(мянган хүн)

	2017	2018	2019	2020	2021	2022
Хүн амын тоо	3089.6	3153.2	3216.5	3279.4	3341.6	3403.1

Эх сурвалж: ҮСХ, Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, 2017.

ҮСХ нь хүн амын хэтийн тооцоог төрөлтийн түвшнээс хамааруулан 3 хувилбараар, тухайлбал төрөлтийн түвшинг бага, дунд зэрэг болон өндөр өсөлттэй хувилбаруудаар хийсэн. Бодлого, төлөвлөлт, судалгаа шинжилгээнд ашиглахад хамгийн тохиромжтой нь хүн амын өсөлтийг их хурдацтай бус, бас хэт удаан биш, харин дундаж хувилбараар тооцох явдал юм. Иймээс Хүснэгт 8-д хүн амын хэтийн тооцооны дундаж хувилбарыг харуулсан болно.

Эдгээр тооцоогоо үндэслэн Хүснэгт 6-д хийсэн Монгол Улсын нэг хүн амд ногдох ҮНО-ын хэмжээнд тодотгол оруулж, дунд хугацааны хүрэх түвшинг бодит байдалд нэлээд ойртуулан засвар оруулна. Гэхдээ энд нэг зарчмыг баримтлах бөгөөд энэ нь Хүснэгт 6-д тооцсон өсөлтийн хэмжээ, түвшинг 2022 он гэхэд үндсэнд нь хадгалах явдал юм. Ингэснээр бид цаашдаа 2030 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтдоо хүрэх боломж бүрдэх болно. Хэрвээ үнэхээр ДНБ-ий урдчилсан төсөөллөөр гол гол шинэ хүчин чадал 2022 оноос хойш ашиглалтанд орж, ДНБ-ий хэмжээ 2022 оноос цааш эрс нэмэгдэх дүр төрхтэй байвал 2018-2022 оны дунд хугацааны хүрэх түвшинг Хүснэгт 6-д тооцооноос багаар тусгаж болох талтай.

Хүрэх түвшинг тооцох арга зүй үзүүлэлт бүрийн хувьд өөрийн онцлогтой байна. Гэхдээ тооцох ерөнхий арга зүй, дарааллын хувьд түүнийг бидний санал болгож байгаа дээрх 3 үе шатаар хийхийг зөвлөмж болгож байна.

Дараагийн жишээ болгон энд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хэмжээг авч үзье. МУТХҮБ-2030-д Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2014 оныг суурь болгон 2030 он хүртэл жил бүр 6,6 хувийн өсөлттэй байхаар авч үзсэн. Эхлээд бид ДНБ-ий хүрэх түвшинг 2014 оныг суурь болгон жил бүр тогтмол 6,6 хувь өссөн тохиолдолд 2030 он хүртэл ямар байхыг баримжаалан тооцъё.

Хүснэгт 9. ДНБ-ий 2014-2030 оны хүрэх түвшний төсөөлөл, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

(тэрбум төгрөг)

	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	5482.3	16504.1	17593.4	18754.6	19992.4	21311.9	22718.5	24217.9

2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
25816.3	27520.2	29336.5	31272.7	33336.7	35536.9	37882.3	40382.5	43047

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

ДНБ жил бүр 6,6 хувиар өссөн тохиолдолд 2022 он гэхэд 2010 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 25816,3 тэрбум төгрөгт хүрч, түүний бодит өсөлт нь 2014 оныхоос 66,7 хувь болсон

байхаар гарч байна. Гэвч ДНБ-ий бодит өсөлт 2015 онд 2,4 хувь, 2016 онд дөнгөж 1 хувь байсан бөгөөд дундаж үзүүлэлт 6,6 хувьд хүрээгүй юм. Иймээс бид ДНБ-ий зорилтот өсөлтийг хангахын тулд дараа дараагийн онуудад түүний өсөлтийг шингээж өгөх, ДНБ зарим жилд 6,6 хувиас харьцангуй өндөр хувиар өссөн байх шаардлагатайг харгалзан үзнэ. ДНБ-ий ийм өсөлтийг хангахын тулд хэдэн онд ямар салбарт хэчнээн хэмжээний хүчин чадлыг ашиглалтад оруулж, ДНБ-ий өсөлтийг хангахыг макро загвартаа тодорхой тусгаж, урьдчилан тооцно.

ДНБ-ий өмнөх онуудын динамик болон өсөлтийн чиг хандлагыг авч үзье.

Хүснэгт 10. ДНБ-ий хэмжээ болон өсөлт

(2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг)

	ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	ДНБ-ий жил бүрийн цэвэр өсөлт, бууралт (хувь)	ДНБ-ий өсөлт, 2000=1
2000	5417.5	1.1	1
2001	5471.7	1	1.01
2002	5690.5	4	1.05
2003	6009.2	5.6	1.11
2004	6646.2	10.6	1.23
2005	7128.3	7.3	1.32
2006	7738.3	8.6	1.43
2007	8531.3	10.2	1.57
2008	9290.6	8.9	1.71
2009	9172.7	-1.3	1.69
2010	9756.6	6.1	1.79
2011	11443.6	17.3	2.11
2012	12853.4	12.3	2.36
2013	14350.7	11.6	2.64
2014	15482.3	7.8	2.84
2015	15847.2	2.4	2.91
2016	16001.8	1	2.94

Эх сурвалж: ҮСХ-ны Статистикийн эмхэтгэл, 2002-2016.

Хүснэгт 11. ДНБ-ий өсөлт

(хувь)


	Өсөлт (хувь)	Жилийн дундаж өсөлт (хувь)
2000-2005	131.6	5.6
2005-2010	136.9	6.5
2010-2015	162.4	10.2
2010-2016	164	8.6
2000-2016	295.37	7

Эх сурвалж: ҮСХ-ны Статистикийн эмхэтгэл, 2017.

Хүснэгтээс харахад 2000-2016 оны хооронд ДНБ-ий жилийн дундаж өсөлт 7 хувь байсан байна. Эндээс харахад ирэх 16 жилд буюу 2030 он хүртэл ДНБ-ийг жил бүр 6,6 хувиар өсгөх зорилт бол хэрэгжих үндэслэлтэй байж болно. Гэхдээ өнгөрсөн 16 жилд манай оронд уул уурхайн салбар эрчимтэй өсч, эдийн засаг хурдан тэлж, өсөж ирсэн билээ. Энэ хурдцыг 2018-2030 онд хадгалж чадвал МУТХҮБ-2030-д эдийн засгийн өсөлтийн талаар дэвшүүлсэн зорилтыг хангах боломж байна гэдэг нь харагдаж байна.

Дээрх аргачлалын зэрэгцээ доороос дээш төлөвлөх, өнгөрсөн онуудын өсөлтийн чиг хандлагыг ашиглан төсөөлөл хийх аргыг тооцоогоо нягтлах, шалгах зориулалтаар давхар хийнэ. Бид Хүснэгт 11-ийн өгөгдлүүдээр доорх графикуудыг шинжилгээ дүгнэлт гаргах зориулалтаар байгуулав.

Зураг 7. ДНБ-ий жил бүрийн бодит өсөлт, бууралт (хувь)




Эх сурвалж: ҮСХ-ны Статистикийн эмхэтгэл, 2002-2017.

Сүүлийн 16 жилийн ДНБ-ий жил бүрийн бодит өсөлт, бууралтаас харахад манай орны эдийн засгийн өсөлт тогтворгүй, зарим жилүүдэд тасралтгүй өсөж байснаа буурч байсан нь тодорхой байна. Эдийн засагт тодорхой өсөлт, бууралтын давтамжтай мөчлөг байгаа нь харагдаж байна. Энэ нь цаашдаа ч мөн манай эдийн засагт үргэлжилнэ гэсэн үг бөгөөд харин үүнийг дунд хугацааны төлөвлөлтөд бодитой зөв харгалзан төсөөлж, хүрэх түвшинг таамаглах нь чухал юм. Зураг 8-аас харахад 2016 онд манай орны эдийн засгийн өсөлт 2011 оноос хойших хамгийн бага түвшинд хүрсэн бөгөөд 2017 онд эхний 3 улирлын дүнгээр 5,3 хувийн өсөлттэй байгаа билээ. Ирэх 2020-2025 онуудад эдийн засгийн өсөлт тасралтгүй нэмэгдэж болзошгүй дүр төрх өнгөрсөн онуудын мөчлөгөөс харагдаж байна.

Одоо бид 2000 оныг суурь болгосон ДНБ-ий өсөлтийг Зураг 9-д харуулав. Энэ нь урт хугацааны өсөлтийн чиг хандлагыг илэрхийлдэг тул төсөөлөл хийхэд ашиглагдана. Уг зургаас харахад харахад манай орны ДНБ-ий бодит хэмжээ (зэрэгцүүлэх үнээр) 2016 онд 2000 оныхоос 2,9 дахин нэмэгдсэн байна. Энэ нь манай эдийн засаг сүүлийн 16 жилд бараг 3 дахин тэлсэн гэсэн үг юм. Excel программ ашиглан байгуулсан доорх график дээрх сүүлийн 16 жилийн өсөлтийн чиг хандлагыг $Y=0,1347x+268,58$ гэсэн шугаман тэгшитгэлээр 2017-2022 оны хүрэх түвшинг тооцон харуулав. Энэхүү шугаман тэгшитгэл нь ДНБ-ий өсөлтийн чиг хандлагыг илэрхийлж байгаа бөгөөд детерминацын коэффициент нь $R=0,949$ байгаа нь чиг хандлагыг нэлээд бодитой 95 хувийн магадлалтай илэрхийлж чадахыг харуулж байна.

**Зураг 8. ДНБ-ий өсөлт, 2010 оны зэрэгцүүлэх үнэ
(хувиар)**



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Зургаас харахад 2022 онд ДНБ-ий хэмжээ 2000 оныхоос ойролцоогоор 3,7 дахин өсөхөөр байгаа нь 2010 оны зэрэгцүүлэх үнээр 20 их наяд төгрөг болж байна. Хүснэгт 10-ын жил бүрийн 6,6 хувийн өсөлтийн тооцоогоор 2022 онд ДНБ-ий хэмжээ 2010 оны үнээр 25,8 их наяд хүрэхээр гарсан билээ. Тэгэхээр өмнөх онуудын өсөлтийн чиг хандлагаар тооцсон тооцоо Хүснэгт 10-ын жил бүрийн 6,6 хувийн өсөлтийн тооцооноос арай бага байгааг тооцоонуудын харьцуулсан дүгнэлтдээ харгалзан үзнэ. Одоо бид хүрэх түвшний талаар 2 тооцоотой болсон бөгөөд энэхүү санал болгож буй арга зүйн 3 дахь шатны тооцоог нийгмийн тооцооны матриц ашиглан хийх макро загвараас гаргах тооцоотой харьцуулан эцсийн засварласан хувилбарыг гаргана гэсэн үг юм.

Хүрэх түвшинг тооцох арга зүй нь үзүүлэлт бүрийн хувьд өөрийн онцлогтой гэдгийг бид дээр дурдсан. Зарим үзүүлэлтийн хувьд жилийн дундаж өсөлтөөр баримжаалж, хүрэх түвшинг тооцох боломжгүй. Энэ тохиолдолд маш тодорхой тооцоо хийж, хүрэх түвшинг тооцно. Жишээ болгон МУТХҮБ-2030-д тусгагдсан нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувьд хүргэх зорилтыг авч үзье.

Монгол Улсын хэмжээнд эрчим хүч үйлдвэрлэх нийт суурилагдсан хүчин чадал 2018 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 1239,5 МВт байгааг эх үүсвэрийн төрлөөр доорх хүснэгтэд ангилан үзүүлээ.

Хүснэгт 12. Эрчим хүчний суурилагдсан хүчин чадал

(мегаватт, хувь)

Эх үүсвэрийн төрөл	Дулааны цахилгаан станц	Дизель станц	Салхин цахилгаан станц	Нарны станц	Усан цахилгаан станц
Хүчин чадал (МВт)	1093.11	2.3	100	20.2	26.19
Эзлэх хувь	88.18	0.01	11.81		

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Дээрх мэдээллээс харахад өнөөдрийн байдлаар Монгол Улсын эрчим хүч үйлдвэрлэх нийт хүчин чадлын 88,2 хувь нь уламжлалт Дулааны цахилгаан станц (ДЦС)-д, 11,8 хувь нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт ногдож байна.

МУТХҮБ-2030-ын 2.1.5.2-д заагдсан 2020 он гэхэд нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20 хувь, 2025 онд 25 хувь, 2030 онд 30 хувьд хүргэх зорилтыг хангахын тулд 80:20, 75:25, 70:30 гэсэн харьцаатай нөхцлийг тухайн заасан хугацааны эцэст хангасан байхаар жил бүр шинээр барих эрчим хүчний эх үүсвэрүүдийн төрлийг сонгон төлөвлөх шаардлагатай болно. Өөрөөр хэлбэл, $Y+X=100$, энд Y -эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадалд уламжлалт эх үүсвэрүүдийн эзлэх хувь; X -эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн эзлэх хувь болно. Иймд бид Y болон X үзүүлэлтүүдийг 2018-2025 оноор нэг бүрчлэн урьдчилан тооцож, нийт суурилагдсан эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг дээрх онуудаар тодорхойлно. Үүний тулд 2018-2025 оны хооронд шинээр ашиглалтад оруулах эрчим хүчний хүчин чадлыг төрлөөр нь бодитой төсөөлөх шаардлагатай. Тухайлбал, ДЦС-4-ийн хүчин чадлыг 2018-2019 нэмэгдүүлэхээр яригдаж байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлж, харин сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлээгүй тохиолдолд X үзүүлэлт буурч, Y үзүүлэлт өснө. Эдгээрийг бодитой урьдчилан тооцох шаардлагатай. Ингэснээр 2018-2025 оны энэ үзүүлэлтийн хүрэх түвшинг бодитой тооцоолох боломжтой.

Үзүүлэлт бүр өөрийн онцлогтойг дээр дурдсан 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл буурч байвал сайн бөгөөд түүнийг МУТХҮБ-2030-д мэдэгдэхүйц бууруулахаар тусгасан. Буурдаг үзүүлэлтийн хувьд хүрэх түвшинг тооцох арга зүй дээр дурдсан үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг тооцсон аргаас арай өөр байх болно. Энэ үзүүлэлт 2014 онд 15,1 промилль байсан бөгөөд 2030 онд 8 промилль болгон бууруулах зорилтыг МУТХҮБ-2030-д тусгасан. Энэ нь ирэх 16 жилд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг 47 хувиар ($((100-8)/15,1=(100-0,53)=0,47$ буюу 47 хувь) бууруулахаар төлөвлөжээ гэсэн үг. Дээр дурдсан аргачлалаар 3 үе шаттай тооцоог хийе.

I үе шат: Жилийн дундаж бууралтын хувийг ашиглан жил бүр жигд буурах нөхцөлд хүрэх түвшинг төсөөлье

Эндээс жил бүр дунджаар хэдэн хувиар буурахыг геометрийн дунджийг доорх томъёогоор тооцно. Энд U -язгуур гаргах жилийн тоо, X -дунджийг тооцох бууралтын коэффициент.

$$\sqrt[16]{x} = \sqrt[16]{0,47} = 0,9539$$

Компьютер доторх тооны машиныг ашиглан энэхүү геометрийн дунджийг тооцвол 0,9539 гарч байна. Уг машины дэлгэцэнд X өгөгдлөө оруулаад гэсэн товчлуурыг дараад араас нь U гэсэн өгөгдөл болох 16 жилээ оруулаад (=) тэмдэг дарахад жилийн дундаж бууралтын хэмжээ гарч ирнэ. Одоо бид суурь он болох 2014 оны нялхсын эндэгдлийн 15,1 промилль гэсэн үзүүлэлтийг 0,9539 гэсэн жилийн дундаж бууралтын

коэффициентоор үржүүлэхэд 2015 оны хүрэх түвшин 14,4 промилль гарна. Энэ мэтчилэн өмнөх оны түвшингээ 0,9539 гэсэн бууралтаар үржүүлэн дараа дараагийн онуудын түвшинг тооцсоныг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 13. 1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдлийн 2030 он хүртэлх жил бүрийн хүрэх түвшний төсөөлөл (промилль)

	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Нялхсын эндэгдлийн түвшин	15.1	14.4	13.7	13.1	12.5	11.9	11.4	10.8

2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
10.4	9.9	9.4	9.0	8.6	8.2	7.8	7.4	8.0

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн хийсэн тооцоо.

Энэ тооцоо бол нялхсын эндэгдэл жил бүр тогтмол 0,9539 буюу 4,6 хувиар (4,6 хувь=100 хувь - 95,4 хувь) буурсан нөхцөлд хүрэх түвшингийн тооцоо юм.

II үе шат: Өмнөх түүхийн талаарх шаардлагатай нэмэлт судалгаа, тооцоо

Нялхсын эндэгдэл гэсэн үзүүлэлтийн өнгөрсөн 16 жилийн өөрчлөлтийг доорх хүснэгтэд харуулав. Хүснэгтээс харахад энэ үзүүлэлт зарим жил өсч, ихэнх онуудад буурч иржээ. 2016 оны түвшин болох 16,8 промилль нь 2000 оны 32,8 байсан түвшингээс 48,8 хувиар (100 хувь - 51,2 хувь=48,8 хувь) буурсан байна.

Хүснэгт 14. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл (промилль)


	Нялхсын эндэгдлийн түвшин, промилль	Жил бүрийн цэвэр өсөлт, бууралтын хувь	Суурь онтой харьцуулсан өсөлт, 2000=1
2000	32.8	0	1
2001	29.5	-10	0.899
2002	29.6	0.3	0.902
2003	23	-22.3	0.701
2004	22.3	-3	0.68
2005	20.7	-7.2	0.631
2006	19.1	-7.7	0.582
2007	17.6	-7.8	0.537
2008	19.4	10.29	0.591
2009	20	3.1	0.61
2010	20.2	1	0.616
2011	16.5	-18.3	0.503
2012	15.5	-6.1	0.473
2013	14.6	-5.8	0.445
2014	15.1	3.4	0.46
2015	15	-0.7	0.457
2016	16.8	12	0.512

Эх сурвалж: ҮСХ-ны Статистикийн эмхэтгэл, 2002-2016.

Энэ үзүүлэлтийн өөрчлөлтийн ерөнхий чиг хандлагыг доорх зурагт харуулав.

Зураг 9. Нялхсын эндэгдлийн түвшин, 2000-2016

(промилль)



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Зургаас харахад нялхсын эндэгдэл ерөнхийдөө буурах чиг хандлагатай байгаа бөгөөд трендийн шулуун шугамд үндэслэсэн төсөөллөөр 2024 онд нялхсын эндэгдэл 5 промилль хүрэхээр гарч байна. Эндээс харахад нялхсын эндэгдлийг 2030 он гэхэд 8 промилльд хүргэхээр МУТХҮБ-2030-д дэвшүүлсэн зорилт хэрэгжих боломжтой байж болохыг харуулж байна.

III үе шат: Жигд өсөлтийн тооцоог бодит нөхцөлд аль болох тохируулан засварлах

Одоо энэ үе шатанд Хүснэгт 7-д хийсэн I үе шатанд жил бүр тогтмол буурахаар төсөөлсөн тооцоогоо 2018-2022 оны түвшинд аль болох бодитой болгон засварлан эцэслэн тогтоох шаардлагатай. Энд Эрүүл мэнд, спортын яамны салбарын мэргэжилтнүүдийн оролцоо зайлшгүй чухал бөгөөд нялхсын эндэгдлийн түвшинд голлон нөлөөлдөг төрөлтийн ерөнхий коэффициентын өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан үзвэл зохино. Мөн 2018-2022 онд эрүүл мэнд, эх нялхсын эрүүл мэндийн талаар төрөөс ямар арга хэмжээ авах, тэр нь өмнөх онуудынхаас хэр нэмэгдэх, нялхсын эндэгдлийг бууруулахад хэрхэн нөлөөлөхийг харгалзан үзнэ.

3.2.2. ДТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг тооцох арга зүй

ДТХЗ-ын хэрэгжилтээр манай орны хувьд гаргах боломжтой үзүүлэлтүүдийг 2020, 2025 болон 2030 он гэхэд ямар түвшинд хүргэхээр зорьж байгааг тодорхойлох хэрэгцээ шаардлага байгаа. Хэдийгээр МУТХҮБ-2030-д тусгагдсан 70 гаруй үзүүлэлтийн хувьд 2030 он гэхэд хүрэх түвшинг тодорхойлсон боловч энэ нь ДТХЗ-ын бүх 169 зорилтыг үнэлэх одоогоор боломжтой үзүүлэлтүүдийн 1/4 гаруй нь болж байгаа юм.

Энэхүү арга зүй нь тодорхой үзүүлэлтийн хэтийн тооцооллын төрөлд хамаарах бөгөөд доорх үндсэн үе шатаар хийгдэнэ.

I үе шат: Эхний ээлжинд өмнөх онуудын тоо мэдээлэлтэй үзүүлэлтийн хувьд олон жилийн (наад зах нь өмнөх 10 жилийн) өгөгдлөөс жилийн дундаж өсөлтийн хувийг тооцно. Энэ үзүүлэлтийг зөвхөн өсөлтийн бус буурах үзүүлэлтийн хувьд ч тооцох бөгөөд жилийн дундаж бууралтын хувийг дээр 3.2.1. хэсэгт харуулснаар тооцно. Өмнөх онуудын тоон мэдээлэл хангалттай байхгүй үзүүлэлтүүдийн хувьд тогтсон норм, нормативтай нөхцөлд түүнийг үндэслэн эсвэл байгаа хугацааны өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан хүрэх түвшинг төсөөлнө. Зарим тохиолдолд хөгжлийн түвшин ойролцоо улс орнуудын дэвшүүлсэн зорилтуудын түвшинг харгалзан үзэж болно.

II үе шат: Өмнөх онуудын жилийн дундаж өсөлт болон бууралтын хувийг 3 хувилбараар (олон жилийн дунджаас доогуур, олон жилийн дундаж орчим, олон жилийн дунджаас дээгүүр) авч, суурь 2017 оноос эхлэн 2025, 2030 онд хүрэх түвшинг тооцно. Энэ нь өмнөх дэд бүлэгт дурдсанаар жил бүр тогтмол өсөлт, бууралттай байх нөхцөлөөр хийсэн тооцоо юм.

III үе шат: Энэ шатанд жигд өсөлт, бууралтаар хийсэн тооцоог бодит нөхцөлд аль болох тохируулан засварлана. Ингэхдээ тухайн салбарт дэвшүүлсэн тэргүүлэх чиглэл, бодлогын зорилтууд, үйл ажиллагааны төлөвлөсөн арга хэмжээ зэргийг харгалзан тухайн үзүүлэлтийн 2025, 2030 онд хүрэх түвшинг төсөөлнө. Тухайн үзүүлэлтэд хүчтэй нөлөөлөх бодлогын чанартай хийсэн интервенц буюу томоохон арга хэмжээний үр нөлөөг тухайн онуудад нь тусгаж өгөх нь чухал юм. Энд томоохон үйлдвэрлэл, үйлчилгээний хүчин чадал, үйлдвэр, дэд бүтцийг ашиглалтад оруулснаас ДНБ-ий хэмжээ эрс нэмэгдэх төлөв зэрэг хамаарна.

Жишээ болгон ДТХЗ-ын Зорилго 8. Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхиүлэн дэмжих гэсэн зорилгын Зорилт 8.2.-ыг авч үзье. Зорилт 8.2.: "Эдийн засгийн төрөлжилт, технологийн шинэчлэл, инновациар дамжуулан, түүний дотор өндөр өртөг шингэсэн, ажиллах хүч ихээр шаарддаг салбаруудад голлон анхаарч эдийн засгийн бүтээмжийн өндөр түвшинд хүрэх" гэсэн зорилт бөгөөд үүнийг үнэлэх гол үзүүлэлт нь "Ажил эрхэлж буй нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт" гэсэн нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт МУТХҮБ-2030-д тусгагдаагүй бөгөөд түүний өмнөх онуудын тоо мэдээлэл хангалттай байгаа билээ.

Хүснэгт 15. Ажил эрхэлж буй нэг хүнд ногдох ДНБ-ий 2000-2016 оны хэмжээ, өсөлт

	ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнэ (тэрбум төгрөг)	Ажиллагчдын тоо (мянган хүн)	Хөдөлмөрийн бүтээмж (мянган төгрөг)	Өсөлтийн индекс (2000=1)
2000	5417.5	809	6696.5	1
2001	5471.7	832.3	6574.2	0.98
2002	5690.5	870.8	6534.8	0.98
2003	6009.2	923.5	6507	0.97
2004	6646.2	950.5	6992.3	1.04
2005	7128.3	968.3	7361.7	1.1
2006	7738.3	1009.9	7662.4	1.14
2007	8531.3	1024.1	8330.5	1.24
2008	9290.6	1041.2	8923	1.33
2009	9172.7	1006.3	9115.3	1.36
2010	9756.6	1033.7	9438.5	1.41
2011	11443.6	1037.7	11027.9	1.65
2012	12853.4	1056.4	12167.2	1.82
2013	14350.7	1103.6	13003.5	1.94
2014	15482.3	1110.7	13939.2	2.08
2015	15847.2	1151.2	13765.8	2.06
2016	16001.8	1147.8	13941.3	2.08

Эх сурвалж: ҮСХ-ны Статистикийн эмхэтгэл, 2002-2016.

Хүснэгтээс харахад нийгмийн хөдөлмөрийн бүтээмж 2000-2016 оны хооронд 2,1 дахин нэмэгдсэн байна. Эндээс 16 жилийн дундаж өсөлт буюу жилд 4,7 хувь өссөн дүн гарч байна. Одоо бид 2025 болон 2030 онд хүрэх түвшинг 3 хувилбараар төсөөлөхийн тулд жилийн дундаж өсөлтийн хувийг эхний бага хувилбараар 4,4 өмнөх 16 жилийн дунджаар 4,7 өндөр буюу өөдрөг хувилбараар жилийн 5 хувийн өсөлттэйгөөр авъя. Энд зөрүү нь 0,3 хувь байгааг анхааралдаа авна уу. Жилийн дундаж өсөлтийн хувь хүрэх түвшинд их мэдрэмжтэй нөлөөлдөг тул зөрүүг багаар авсан болно. Энэ зөрүүг янз бүрээр нэмэгдүүлж, хүрэх түвшинг олон хувилбараар тооцож, зөрүүг сонгон тогтоож болно.

Хүснэгт 16. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн хэтийн тооцоо, 3 хувилбараар (мянган төгрөг)


Он	Жилийн дундаж өсөлтийн 3 хувилбараар		
	4.3%	4.7%	5.0%
2017	14540.8	14596.5	14638.3
2018	15166	15282.6	15370.3
2019	15818.2	16000.8	16138.8
2020	16498.3	16752.9	16945.7
2021	17207.8	17540.3	17793
2022	17947.7	18364.7	18682.6
2023	18719.4	19227.8	19616.8
2024	19524.4	20131.5	20597.6
2025	20363.9	21077.7	21627.5
2026	21239.5	22068.3	22708.9
2027	22152.8	23105.5	23844.3
2028	23105.4	24191.5	25036.5
2029	24098.9	25328.5	26288.4
2030	25135.2	26518.9	27602.8

Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Эхний хувилбар дахь 2017 оны хөдөлмөрийн бүтээмжийн түвшинг 2016 оны түвшин 1.043 гэсэн индексээр үржүүлж, ХБ (2017)=13941,3*1,043=14540,8 гэсэн дүнг гаргасан. Ийм байдлаар өмнөх оны түвшинг жилийн дундаж өсөлтийн тохирох хувилбараар үржүүлж дараа оны түвшинг тооцно. Энэ нь дээр дурдсанаар жил бүр тогтмол өсөлт, бууралттай байх нөхцөлөөр хийсэн 3 хувилбартай тооцоо юм.

Одоо өмнөх 16 жилийн өсөлтийн шулуун шугаман чиг хандлагаар энэ үзүүлэлтийн прогнозыг Excel программ дээр графикаар дүрслэн харуулъя.

Зураг 10. Хөдөлмөрийн бүтээмж
(мянган төгрөг)



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны багийн тооцоо.

Зургаас харахад 2030 онд энэ үзүүлэлтийн түвшин 21300 мянган төгрөг орчим гарч байна. Гэтэл манай доод хувилбараар 25135,3 гарсан билээ. Үүнийг хувилбар сонгохдоо харгалзан үзэж болно.

Одоо бид сүүлийн шатанд 3 хувилбартай тооцоог бодит нөхцөлд аль болох тохируулан засварлана. Ингэхдээ тухайн салбарт дэвшүүлсэн тэргүүлэх чиглэл, бодлогын зорилтууд, үйл ажиллагааны төлөвлөсөн арга хэмжээ зэргийг харгалзан тухайн үзүүлэлтийн 2025, 2030 онд хүрэх түвшинг 3 хувилбараас сонгон төсөөлнө. Манай жишээгээр авсан үзүүлэлт нь аль нэг салбарын үзүүлэлт бус, макро түвшний үзүүлэлт тул хамгийн гол нь дээрх үзүүлэлтэд оролцсон 2 үзүүлэлт, тухайлбал, ДНБ-ний хэмжээ болон ажил эрхлэх хүн амын тоог он тус бүрд нь зөвөөр төсөөлж тооцох шаардлага гарч байна. Гэхдээ 16 жилийн хувьд жил бүрийн өөрчлөлтийг урьдчилан төсөөлөхөд хэтэрхий урт хугацаа учир тодорхой хүндрэл гарна. Харин 2025 он хүртэл ДНБ-ний хэмжээ ямар болох, ажил эрхлэх хүний тоо хэрхэн өөрчлөгдөхийг тооцоолж болно. ДНБ-ний хэмжээг ЕТЗ загвараар 2025 он хүртэл хийсэн тооцоо болон ҮСХ-ноос гаргасан хүн амын хэтийн тооцоог үндэслэн өмнөх онуудын ажил эрхлэлтийн дундаж түвшингээр ажил эрхлэх хүний тоог 2030 он хүртэл тооцож болно.

Хэрэв 2025 он хүртэл бодитой засвар оруулсан бол 2025-2030 онуудын түвшинг дундаж өсөлтийн 3 хувилбарын аль нэг сонгосон хувилбараар үргэлжлүүлэн тооцоолж, 2030 онд хүрэх түвшинг тодорхойлно.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол.
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, 2015.
3. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, УИХ-ын 1996 оны 26 дугаар тогтоол.
4. Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 1998 оны 82 дугаар тогтоол.
5. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол.
6. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол.
7. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого, УИХ-ын 2015 оны 63 дугаар тогтоол.
8. "Монгол Улсын статистикийн эмхэтгэл", Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, 2017.
9. Matthew B.Miles, A.Michael Huberman 1994, "Qualitative data analysis: an expanded sourcebook" 2nd edition, p27.
10. Nina Weitz, Hencik Carlsen, Mans Nisson Kristain Skanberg, "Toward systematic and contextual priority setting for implementation the 2030 Agenda", 2017.
11. Mongolia's Sustainable Development agenda: progresses, bottlenecks and vision for the future. By UNDP, GoM, 2012.
12. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэн тусгах нь: Малайз улсын жишээ, туршлага.
13. Thomas A.Birkland, "An introduction to the policy process: theories, concepts, and models of public policy making", 2016.
14. Maria J.Grant & Andrew Booth, "A typology of reviews: an analysis of 14 review types and associated methodologies", Salford Centre for Nursing, Midwifery and Collaborative Research (SCNMCR), University of Salford, UK, School of Health and Related Research (SchARR), University of Sheffield, UK, 2009.
15. Angela Harden, "Mixed Methods Systematic Reviews: Integrating Quantitative and Qualitative Findings", 2010.
16. "Integrated Approaches for Sustainable Development Goals Planning: case of Goal 6 on Water and Sanitation", United Nations, 2017.
17. Zac Tate, "Capitalism is losing support. It is time for a new deal", WEF, 2017.
18. "Handbook on planning, monitoring and evaluation for development result", UNDP, 2009.
19. Jodi Thesenvitz, Larry Hershfield and Robb MacDonald, "Priority setting process check list (PSPC)", Public Health, Ontario, 2011.
20. Malaysia planning case.
21. Policy handbook.
22. "Scenarios for Mongolia", WEF, 2014.
23. "Policy and Institutional Analysis", IFAD, SL Workshop.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Сайн бодлого төлөвлөлтийн 10 шалгуур ба шаардлага

1. Ирээдүйд чиглэсэн

Тухайн бодлогын хүрэх үр дүнг ойлгомжтой тодорхойлсон байх шаардлагатай. Ингэхдээ нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын өнөөгийн хандлага, цаг уурын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, статистик мэдээлэлд суурилан наад зах нь ирэх 5 жилд гарах үр нөлөө, үр дагаврыг таамагласан зураглалыг гаргах хэрэгтэй. Энэ нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зорьж буй үр дагаврыг эхний үе шатанд боловсруулах;
- Болзошгүй эрсдэлийг урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулахдаа авч үзэх.

2. Гадаад орчинтой уялдсан байх

Бүс нутаг, улс орон, олон улсын нөхцөл байдал, нөлөөлөх хүчин зүйлсийг авч үзэн туршлагаас нь суралцах. Энэ нь дараах шаардлагыг хангах ёстой:

- Олон улсын туршлагаас суралцах, бусад улс орнууд тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг судлах;
- Монгол Улсын хувьд гарч болох онцлог байдал, зөрүүг хүлээн зөвшөөрөх.

3. Шинийг эрэлхийлсэн, уян хатан бүтээлч байх

Уян хатан, шинийг эрэлхийлсэн, нэгэнт тогтсон арга замын талаар асуулт тавьсан, шинэ бүтээлч санааг дэмжиж, шаардлагатай үед арга барилаа тогтмол сайжруулах. Үйл явц нь холбогдох оролцогч талууд, ялангуяа нийгмийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа бүлгийн дуу хоолойг сонсох боломжийг нээлттэй байлгах. Эрсдлийг тодорхойлон, сайн удирддаг байх. Энэ нь дараах алхмуудыг хийсэн байхыг шаардана:

- Хуучин арга барилаас илүү шинэлэг арга барилд (үзэл бодлоо уралдуулах гэх мэт) суралцах;
- Хүссэн үр дагавраар амжилтыг үнэлэх;
- Эрсдэлийг үнэлэн, үр дүнтэй удирдах;
- Шинэ санааг дэмжсэн удирдлагын бүтэц, багийн үр дүнтэй ажиллагаа явуулах алхмыг хийдэг байх;
- Бодлого боловсруулах багт холбогдох талуудыг оролцуулдаг байх;
- Байгалийн нөөцийг зохистой ашиглах.

4. Нотолгоонд тулгуурлах

Бодлого боловсруулагчдын зөвлөмж, шийдвэр нь олон эх үүсвэрээс авсан хамгийн сайн нотолгоонд суурилсан байдаг. Нийт оролцогчид бодлого боловсруулалтын эхний үе шатнаас эхлэн боловсруулж дуусах хүртэл бүхий л шатанд оролцоно. Энэ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Өмнөх судалгаанд суурилах;

- Шинээр судалгаа явуулах;
- Холбогдох мэргэжилтэнтэй зөвлөлдөх, дотоод болон гадаад зөвлөхүүдтэй санал солилцох, өртөг, зардлыг зөв тооцож үнэлсэн хувилбаруудыг авч үзэх.

5. Тэгш хүртээмжтэй байх

Бүх оролцогчдын эрэлт, хэрэгцээг хангах бодлогын шууд болон шууд бус нөлөөллийг авч үзэх. Энэ нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- Үйлчилгээ үзүүлэгч, хэрэгжүүлэгчидтэй зөвлөлдөх;
- Эцсийн хүлээн авагч буюу бодлогын нөлөөг хүртэх хүмүүстэй зөвлөлдөх;
- Нөлөөллийн үнэлгээг хийх;
- Эцсийн хэрэглэгчид болон үйлчилгээ хүргэгч нараас бодлогын талаар санал авах, байр суурийг сонсох.

6. Хамтарсан байх

Стратегийн зорилтыг байгууллагын чиг үүргээс илүү чухалчлан, бодлогын ёс зүй, ёс суртахуун, эрх зүйн суурийг бүрдүүлж, бодлогын нэгдсэн, цогц байдлыг хангах. Салбар хоорондын зорилтыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын зохистой тогтолцоог гаргах. Энэ нь дараах алхмуудыг хийсэн байхыг шаардана:

1. Хамгийн түрүүнд салбар хоорондын зорилтыг нарийвчлан тодорхойлох;
2. Бусад газруудтай хамтран ажиллах зохион байгуулалтыг тодорхойлж, сайжруулах;
3. Үр дүнтэй хамтран ажиллахад учрах саад, бэрхшээл, түүнийг даван туулах арга замыг тусгах;
4. Хэрэгжилтийг бодлого боловсруулах үйл явцын бүрэлдэхүүн хэсэг болгосон байх.

7. Сургамжаас суралцсан байх

Сургамжаас суралцах арга барил нь дараах шаардлагатай:

1. Авсан сургамж, шилдэг туршлагын талаар мэдээллийг түгээн дэлгэрүүлэх;
2. Сургамжаас суралцсаны үр дүнд бодлого боловсруулагч ямар арга хэмжээ авсан тухай мэдээлэл солилцох;
3. Алдаатай бодлогын нөлөө болон хэрэгжилтэд гарсан алдаа хоёрыг нарийн ялган зааглах.

8. Харилцаа

Олон нийтэд бодлогыг хэрхэн хүргэх асуудлыг авч үзэх. Энэ нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- Олон нийттэй харилцах болон хүргэх стратегийг боловсруулан хэрэгжүүлэх;
- Эхний үе шатнаас эхлэн удирдлагыг мэдээллээр хангах.

9. Үнэлгээ хийх

Бодлогын үр дүнтэй байдалд системтэй үнэлгээ хийхийг бодлого боловсруулах үйл явцад суулгаж өгөх. Энэ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Үнэлгээний зорилтыг эхнээсээ нарийвчлан тодорхойлох;
- Амжилтын шалгуурыг тодорхойлох;
- Үнэлгээний аргачлалыг тогтоох;
- Бодлогын эцсийн үр дагаврыг үнэлэх аргачлалыг турших.

10. Хяналт тавих

Хэрэгжүүлж буй бодлого нь шийдвэрлэхээр зорьж буй асуудалд чиглэгдэж чадаж байгаа эсэхэд гарч болох өөрчлөлтийг авч үзсэнээр тогтмол хяналт тавих. Энэ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хэрэгжилтийг зохистой хэмжих үзүүлэлт бүхий байнгын хяналтын хөтөлбөртэй байх;
- Үйлчилгээ үзүүлэгч болон эцсийн хэрэглэгчдээс бодлого боловсруулагч нарт санал бодлоо хүргэх механизмтай байх;
- Давхардсан эсвэл амжилтгүй бодлогыг зогсоох.

Эх сурвалж: <http://managementstudyguide.com>

Хавсралт 2. ТЭХТББ "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан байдал

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтууд	1-шууд тусгагдсан 2-агуулгын хувьд уялдсан 3-огт тусгагдаагүй
Тэргүүлэх чиглэл 1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах	
Зорилго 1.1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах.	
1.1.1. Анхдагч эрчим хүч, түлшний хангамжийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх;	1
1.1.2. Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгох;	1
1.1.3. Эрчим хүчний нэгдсэн системийн цахилгааны ачааллын хэлбэлзлийг тохируулж, хэвийн найдвартай ажиллагааг хангах тохируулгын эх үүсвэрийг бий болгох;	3
1.1.4. Хот, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах, дулаан хангамжийн дэд бүтцийг хөгжүүлэх;	1
1.1.5. Бүс нутгийн эрчим хүчний системийг дамжуулах чадал өндөр цахилгаан дамжуулах шугамаар холбож, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах;	1
1.1.6. Цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хэрэглэгчид хүргэх эрчим хүчний чанарыг сайжруулах.	3
Зорилго 1.2. Бүс нутгийн орнуудтай эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх.	3
1.2.1. Хөрш орнуудтай эрчим хүч импортлох, экспортлох урт хугацааны харилцан ашигтай гэрээ байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх;	3

1.2.2. Олон улсын байгууллага, бүс нутгийн орнуудын эрчим хүчний хамтын ажиллагааны санал санаачилгад идэвхтэй оролцох, хамтран ажиллах;	3
1.2.3. Монгол орны говийн бүсийн нар, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбороос Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачилгыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах;	3
1.2.4. Эрчим хүчний чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах.	3
Зорилго 1.3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах.	3
1.3.1. Эрчим хүчний инженер-техникийн ажилтан бэлтгэх дотоодын сургалтын байгууллагын сургалтын чанарыг сайжруулах, салбарын инженер-техникийн ажилтан, менежерийн чадамжийг олон улсын түвшинд хүргэх;	3
1.3.2. Эрчим хүчний эдийн засаг, үйлдвэрлэл, туршилт, тохируулгын судалгаа, хөгжлийн үндэсний хүрээлэнг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;	3
1.3.3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийн балансыг зохистой түвшинд хадгалан удирдлагын бүх түвшинд мэргэжлийн боловсон хүчний шаталсан байршуулалтын тогтолцоог мөрдөх.	3
Тэргүүлэх чиглэл 2. Эрчим хүчний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх	
Зорилго 2.1. Эрчим хүчний салбарыг хувийн хэвшилд суурилсан, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх.	3
2.1.1. Бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан, үнэ тарифийн тогтолцоог бий болгож, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах;	3
2.1.2. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;	3
2.1.3. Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.	3
Зорилго 2.2. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх.	
2.2.1. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны удирдлага, хяналт, мэдээллийн системийг тоон системд бүрэн шилжүүлж, нэгдсэн ухаалаг сүлжээг бий болгох;	3
2.2.2. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;	1
2.2.3. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээн дэх алдагдлыг бууруулах;	3
2.2.4. Үндэсний хэмжээнд эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэглэгч талын менежментийг хөгжүүлэх;	3
2.2.5. Эрчим хүчний хэрэглээ тооцох механизмыг бүрэн хэмжүүржүүлэх.	3
Тэргүүлэх чиглэл 3. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих	
Зорилго 3.1. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.	

3.1.1. Монгол орны сэргээгдэх эрчим хүч /нар, салхи, ус, газрын гүний дулаан, биомасс зэрэг/-ний нөөцийг нарийвчлан тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэ техник, технологийн судалгаа, шинжилгээ хийх байгууллагыг хөгжүүлэх;	3
3.1.2. Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувь хүртэл нэмэгдүүлэх;	1
3.1.3. Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүй, татварын таатай орчныг бүрдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизмыг бий болгох;	3
3.1.4. Айл өрх, аж ахуйн нэгж, алслагдсан суурин, баг, бие даасан хэрэглэгчийн эрчим хүчний хангамжид нар, салхи, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглах, илүүдэл эрчим хүчээ сүлжээнд нийлүүлэхийг дэмжих;	3
3.1.5. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааны байгаль орчин, экологид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах;	3
3.1.6. Байгаль орчны нөлөөллийн хяналтыг сайжруулах.	3



Үндэсний хөгжлийн газар
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний Гудамж 5/1
Засгийн газрын II байр
Утас: 976-51-263333
www.nda.gov.mn